



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон

Утас: 26-45-25, Факс: 32-70-16

E-mail: amgalanbaatar@parliament.mn

<http://www.parliament.mn>

2025-11-27 № 412-03/13519
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт-2 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2025000518

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

Д.АМАРБАЯСГАЛАН



Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ



Н.АЛТАНШАГАЙ

С.АМАРСАЙХАН

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ



М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

2025000518

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

2025000519



Э.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

2025000518

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН



С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

2025000518



М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА



Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

2025000518

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

2025090518

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Дав.ЦОГТБААТАР

Дам.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

2025000519

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА



Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

2025000518



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-45-25, Факс: 32-70-16
E-mail: amgalanbaatar@parliament.mn
http://www.parliament.mn

2025.09.17 № УИХ-03/10566
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд УИХ-ын гишүүн миний бие, УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан, Н.Алтаншагай, М.Бадамсүрэн, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Д.Батлут, Ж.Батсуурь, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бейсен, Х.Болормаа, Г.Ганбаатар, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, П.Наранбаяр, О.Номинчимэг, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Б.Түвшин, Д.Энхтуяа нарын хамт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу Засгийн Газрын санал дүгнэлт авах тухай 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/7559 тоот албан бичгийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн боловч ямар нэгэн хариу, санал дүгнэлт ирээгүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулсан тус хуулийн төслийг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хавсаргав.

Хавсралт: ~~1/6~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2025000413



**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

“Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн 5.2-т 2050 он гэхэд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бие даан хөгжих нөхцөлийг бэхжүүлсэн байна”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” баримт бичгийн 5.4-д “Аймаг, нийслэл, сумын хот байгуулалтын баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж тусгасан.

Түүнчлэн “Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэж тусгасан. Мөн Тавин найм дугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /МУЗЗНДНТУтХ/-ийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх”-ээр тусгажээ.

МУЗЗНДНТУТХ-ийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-ийг засаг захиргааны нэгж тус бүрээр нь ангилан тогтоосон боловч орон нутгийн чиг үүргийн хуваарилалт нь оновчтой эсэх, орон нутгийн чиг үүрэгт хамаарах салбарын хууль тогтоомж нийцэж байгаа эсэх талаар судлах хэрэгцээ тулгамдсан асуудал хэвээр байна. МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгаар орон нутгийн чиг үүргийг төрийн чиг үүргээс зааглан, улмаар орон нутгийн нэгж хоорондын чиг үүргийн давхардлыг арилгаж, орон нутгийн удирдлагын чиг үүрэг бүрийг зааж өгсөн хэдий ч тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх агентлагийг удирдлага арга зүйгээр хангах, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдах, төлөвлөх, хариуцах боломж бүрдээгүй байгаа нь тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж, МУЗЗНДНТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “нэгжийн удирдлага” гэж нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тогтолцоо, үйл ажиллагааг, 4.1.3-д “нутгийн өөрийн удирдлага” гэж иргэд шууд, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг, 4.1.4-д “нэгж дэх төрийн удирдлага” гэж бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг, 4.1.6-д “орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг, 4.1.8-д “төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг” гэж нэгжийн удирдлагад төрөөс шилжүүлсний дагуу түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг гэж тус тус заасан байна.

Гэсэн хэдий ч хуульд заасан орон нутгийн болон төлөөлөн гүйцэтгүүлэх төрийг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, засаг дарга нь засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг удирдлага арга зүйгээр хангах, Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөхөд агентлагуудын үйл ажиллагааг уялдуулах, дэмжих, хариуцлага тооцох боломж бүрэн хангагдахгүй байна. Түүнээс гадна аймаг, сумдад хүний нөөцийн чадавх, хомсдол зэргээс хамаарч мэргэшсэн төрийн албан хаагчийн дутагдалтай байдлаас хамаарч удирдах албан тушаалд ажиллуулах асуудалд хүндрэл учирсаар байна.

Иймд доорх асуудлуудыг нэг мөр зохицуулж, засаг дарга нэг талаас орон нутгийн нөгөө талаас төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлж, иргэдийн хурлын өмнө болон Засгийн газрын өмнө хариуцлагаа бүрэн хүлээх нөхцөлийг бүрдүүлж, засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийг тухайн салбарын төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлж, улмаар

мэргэшсэн төрийн албан хаагч орон нутгийн сонгуульд өрсөлдөх, сонгогдсон тохиолдолд тодорхой хувь нь төрийн албыг давхар хаших замаар төрийн залгамж чанар, мерит зарчмыг хослуулах боломжийг бүрдүүлэх үүднээс МУЗЗНДНТУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

А.Өнөөдрийн байдлаар жишээ нь аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлагийг Засгийн газраас баталж өгсөн хэдий ч засаг дарга дөнгөж 6 агентлагийн даргыг томилж чөлөөлөх асуудлыг тухайн салбарын хуулиар олгосон байдаг. Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж чөлөөлөх, хариуцлага тооцох асуудлыг МУЗЗНДНТУТХ-д нэмэлт оруулж тусгаж өгөх шаардлагатай бөгөөд ингэснээр тухайн салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл бүрдэх юм.

Б.Аймаг, сум буюу хөдөө орон нутагт мэргэшсэн хүний нөөцийн дутагдал байсаар байгаа бөгөөд төрийн албан хаагч нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг сонгох сонгуульд нэр дэвших тохиолдолд ажил үүргээсээ чөлөөлөгдөх улмаар сонгогдсон тохиолдолд аймгийн хувьд төрийн захиргааны албан тушаалыг давхар хаших боломжгүй байгаа юм. Орон нутагт албан тушаал дэвших, карьер хөөх, мэргэших боломжийг хуулиар хязгаарлах тусам орон нутгаас нийслэл рүү шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, орон нутагт мэргэшсэн албан хаагч ажиллах боломж бүрдэхгүй байна. Энэ агуулгаар суманд ИТХ-ын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэсэн зохицуулалтыг МУЗЗНДНТУТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.6-д “аймаг” гэж нэмж тусгаж өгөх практик хэрэгцээ шаардлага үүсч байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана:

- Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх асуудлыг МУЗЗНДНТУТХ-д аймаг, дүүрэг, нийслэлийн засаг даргын бүрэн эрхэд нэмж тусгаж өгөх;

- Мэргэшсэн төрийн албан хаагчийг тогтоон барих, түүнийг дэвших, орон нутагтаа карьер хөөх боломжийг олгох үүднээс сумын ИТХ-ын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэсэн заалтын нэгэн адил утгыг аймгийн ИТХ-д олгож өгөх асуудлаар хуулийн холбогдох хэсгийг өөрчлөн найруулах;

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

МУЗЗНДНТУтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

1/аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэсэн Үндсэн Хуулийн заалт хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ;

2/нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тогтолцоо, үйл ажиллагааг "нэгжийн удирдлага" гэж заасны дагуу засаг дарга хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах хуулийн хэрэгжилт хангагдана.

3/Аймаг, сумын мэргэшсэн төрийн захиргааны албан хаагчид орон нутагтаа шат ахин дэвших, карьер хөөх боломж бүрдэж орон нутагт мерит зарчим хэрэгжих нөхцөл бүрдэнэ;

4/МУЗЗНДНТУтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх эрх зүйн боломж нээгдэнэ;

Дээрх эерэг үр дагаврууд гарснаар Монгол Улсын засаг захиргааны нэгжүүдэд орон нутгийн болон төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг орон нутгийн удирдлагын болоод засаг төрийн төлөөлөгчийн хувьд засаг даргад эрх олгогдож хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мөн Монгол Улс нэгдмэл улсын хувьд орон нутагт эрх мэдлийг нэмэгдүүлэх асуудал нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа бөгөөд МУЗЗНДНТУтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нэгэнт хуулиар тогтоосон орон нутгийн чиг үүргийг хөндөхгүй бөгөөд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг тусгасан болно. МУЗЗНДНТУтХ-ийн 76 дугаар зүйлийн 76.3-д "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн зохицуулах хуулийг зөвхөн Засгийн газар санаачилна" гэж заасан нь нэгдмэл улсын бодлогыг тусгасан, хуулиар нэгэнт тогтоосон орон нутгийн чиг үүргийг өөрчлөх, төрийн чиг үүрэгтэй холих асуудлаас сэргийлж, уг асуудлаар хуулийн төсөл санаачлах хүрээ хязгаараар хамгаалсан заалт гэж ойлгож байгаа болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг томилж чөлөөлөхтэй холбоотойгоор дараах хуулиудад өөрчлөлт оруулна. Үүнд:

1. Боловсролын ерөнхий хууль
2. Хүүхэд хамгааллын тухай хууль
3. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
4. Эрүүл мэндийн даатгалын тухай
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
7. Нийгмийн халамжийн тухай хууль
8. Соёлын тухай хууль
9. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
10. Статистикийн тухай хууль
11. Татварын Ерөнхий хууль
12. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
13. Усны тухай хууль
14. Гамшгаас хамгаалах тухай
15. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай
16. Цагдаагийн тухай хууль
17. Улсын бүртгэлийн ерөнхий хууль

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд^{1/} МУЗЗНДНТУтХ/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 5 зүйлтэйгээр боловсруулсан.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-3 дах заалтаар МУЗЗНДНТУт хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дахь заалтад “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх” гэсэн заалт нэмэхээр тусгасан талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр МУЗЗНДНТУт хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд уг шинэчилсэн найруулгаар орон нутгийн чиг үүргийн давхардлыг арилгаж, баг, сум, аймаг, хороо, дүүрэг, нийслэлийн иг үүргийг зааглан, улмаар тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх, үүргийг тухайн шатны засаг даргад тусгайлан олгосон байдаг. Энэ хүрээнд:

1.1.МУЗЗНДНТУт хуулийн 60 дугаар зүйлд Аймгийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

1.2.МУЗЗНДНТУт хуулийн 62 дугаар зүйлд Дүүргийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

1.3.МУЗЗНДНТУт хуулийн 63 дугаар зүйлд Нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтаар МУЗЗНДНТУт хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулахаар тусгасан талаар:

ОДООГИЙН ЗОХИЦУУЛАЛТ	ТӨСЛИЙН ХУВИЛБАР
38.6.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх	"38.6.Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн

¹ 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэх дагаж мөрдсөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/16106891904801>

хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.

гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно;" гэж **өөрчлөн найруулах.**

Энэ өөрчлөлт оруулснаар хөдөө орон нутаг төрийн захиргааны мэргэшсэн, туршлагатай албан хаагч нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшин, улмаар сонгогдсон тохиолдолд төрийн захиргааны албан тушаалаа давхар хаших боломж бүрдэх бөгөөд үүнийг сумын нэгэн адил нийт ИТХ-ын гуравны нэг хүртэлх хувь нь давхар байж болохоор тусгасан болно. Өөрөөр хэлбэл, аймгийн засаг дарга нь тухайн шатны ИТХ-ийн төлөөлөгчөөр нэр дэвшин сонгогдсон төрийн захиргааны албаны туршлагатай, мэргэшсэн албан хаагчийг тухайн албан тушаалд үлдээх, улмаар дэвшүүлэн томилох замаар мерит зарчмыг төрийн албанд хангуулахад чухал ач холбогдолтой зохицуулалт болох юм.

4.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд тухайн хуульд нэмэлтээр оруулсан заалтын улмаар хуулийн зарим заалтын дугаар өөрчлөгдөж буй талаар:

4.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21-д "Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 60.1.21 дэх заалтын дугаарыг "60.1.22" гэж,

4.2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13-д "Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 62.1.13 дахь заалтын дугаарыг "62.1.14" гэж,

4.3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.13-д "Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 63 дугаар зүйлийн 63.1.13 дахь заалтын дугаарыг "63.1.14" гэж, 63.1.14 дэх заалтын дугаарыг "63.1.15" гэж, 63.1.15 дахь заалтын дугаарыг "63.1.16" гэж тус тус өөрчилсөн.

5.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн тайлбарыг хасахаар тусгасан талаар:

Хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан байх бөгөөд 2024 оны 2024 оны орон нутгийн ээлжит сонгууль нэгэнт болж өнгөрснөөр энэ зүйл хэрэгжиж эхлээд байгаа болно. Иймд энэ зүйл хэсгийг өөрчлөн найруулж, уг зүйлийн зохицуулалт нь зөвхөн "сумын" гэж байсныг "аймаг" гэж нэмж найруулснаар хуулийн зүйлийн дараах тайлбарыг хасах нөхцөл бүрдсэн болно.

"Тайлбар: -Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөх бөгөөд 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дүн гарах хүртэл аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын

Төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан тушаал эрхэлж болно."

6.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан талаар:

Хуулийн төсөлд Засаг даргад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрхийг олгосноор өмнөх удирдлага жилийн үйл ажиллагааны тайланг тавих, ажил үүргээ дүгнүүлэх боломжийг олгох үүднээс хууль батлагдсаны дараагийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхөөр тусгалаа.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Нэг.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.”,

Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.”, Жаран нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.”, Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.”, Жаран хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.” гэж тус тус заасан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.2 дахь зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд “I үе шат (2021-2030): Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе.” хэсгийн 2 дахь заалтад “Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оновчтой хуваарилалт бий болж, орон нутгийн бие даасан байдал хангагдана” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 онд хийгдсэн бөгөөд уг шинэчилсэн найруулгаар засаг захиргааны нэгж, нутгийн удирдлагын чиг үүргийг тодорхойлж, улмаар чиг үүргийг давхардалгүй, хийдэлгүй тодорхойлсны дээр нутгийн удирдлагын чиг үүргээс гадна төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэхээр мөн хуульд тодорхой зааж өгсөн байдаг.

Иймд орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа

байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцах хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг удирдлагаар хангах, тэдний ажлын хариуцлагыг ч мөн өөрөө давхар хариуцахаар хуульчлагдсан. Иймээс харьяа нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нь засаг төрийн төлөөлөгчийн хувьд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын төлөвлөлт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, чадварлаг төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, урьж ажиллуулах зэргээр удирдлага, зохион байгуулалтын эрхийг нь мөн шилжүүлж өгөх шаардлага үүсч байгаа болно.

Иймд орон нутгийн удирдлагад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагын томилгоог хийх боломжийг холбогдох хууль тогтоомжид тусгаж өгөх, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд шаардлагатай нэмэлт оруулах явдал болно.

Хоёр.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6-11 дүгээр зүйлд засаг захиргааны нэгжийг тодорхойлж, тухайн засаг захиргааны нэгжийн орон нутгийн чиг үүргийг 20 дугаар зүйлд, мөн нэгж бүрээр зааглан 21-26 дугаар зүйлд тус бүр нарийвчлан давхардалгүйгээр тодорхойлж өгсөн байдаг. Ингэхдээ чиг үүргийг а).Эдийн засаг, төсвийн талаар орон нутгийн чиг үүрэг, б).Бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх талаарх орон нутгийн чиг үүрэг, в).Зохицуулалтын шинжтэй чиг үүрэг, г).Үйлчилгээ, аж ахуйн талаарх орон нутгийн чиг үүрэг гэсэн 4 хүрээнд тусгайлан тодорхойлсон байдаг.

Төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бодлого хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээ, аж ахуйн талаарх чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлдэг агентлагуудын удирдлагын томилгоог орон нутаг, засаг даргад шилжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Иймээс төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх агентлагуудын орон нутаг дахь байгууллагын захирал, удирдлагуудыг томилох, чөлөөлөх эрхийг хуулиар Засаг даргад олгох асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тусгах, салбарын хуулиудад зааж өгөх зохицуулалтыг энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгалаа.

Гурав.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилохтой холбогдсон харилцааг хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгтэй холбоотой харилцааг тусгайлан зохицуулахаар тусгаж, 27 дугаар зүйлийн 27.5-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах

төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ.” гэж 27 заалтад холбогдох чиг үүргүүдийг жагсааж өгсөн байдаг.

Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн дараагаар Засгийн газраас Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталж, улмаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагуудыг жагсаалтаар баталж өгсөн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох” тухай 37 дугаар тогтоолоор аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 газар, хэлтсийг тогтоож өгчээ.

Харин тухайн агентлагуудын удирдлагын томилгоог салбарын хуулиудад төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын удирдлагын эрх, үүрэгт хамааруулан холбогдох хэсэг, заалтаар зааж өгсөн байдаг.

Дөрөв.Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар санаачлан УИХ дахь Ардчилсан намын бүлэг, Монгол ардын намын бүлгийн зарим гишүүдэд хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулж улмаар УИХ-ын гишүүд хамтран ажиллаж, олон нийт, орон нутгийн засаг захиргааны нэгжийн удирдлагуудын хүрээнд удаа дараагийн хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллаж эхлээд байна.

Мөн хуульд зааснаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн хэрэгцээ шаардлага болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний ажилд мэргэжлийн хуульч, судлаачидтай гэрээ байгуулан хамтран ажилласан болно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“20.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.хуулийн төсөлд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх бүрэн эрхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад олгохоор тусгаж, үүнтэй холбогдуулан дагалдах бусад хуулийн төсөлд тухайн шатны Засаг дарга эрх бүхий этгээдтэй зөвшилцсөний үндсэн дээр болон тухайн шатны Засаг даргын санал болгосноор албан хаагчийг томилж, чөлөөлөх зохицуулалтыг оруулсан нь Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3 дахь заалтад заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална” гэж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт “онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна” гэж, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт “татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна” гэж, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт улсын бүртгэлийн үйл ажиллагаанд “нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх, төвлөрсөн удирдлагатай байх, хараат бус байх” зарчмыг баримтлахаар заасантай тус тус зөрчилдөж байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн дээрх зохицуулалт нь нэгдсэн бодлого, төвлөрсөн удирдлага, босоо шаталсан тогтолцоотой, тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоог алдагдуулах, хууль хоорондын зөрчил үүсгэх эрсдэлтэй байна;

2.төрийн захиргааны албан тушаал нь Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэгтэй.

Гэтэл хуулийн төсөлд “аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно” гэж тусгасан нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан “мэргэшсэн, тогтвортой байх”, “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх” төрийн албаны зарчимд нийцэхгүй бөгөөд мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна.

Түүнчлэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад “нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн чиг үүргийг зааглах зарчмыг баримтална” гэж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт “нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагчийн ажил, албан тушаал эрхэлж байгаа бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна” гэж тус тус заасантай зөрчилдөж байна;

3.Хуулийн төслийн зохицуулалт нь иргэдийн төлөөллийг хэрэгжүүлэх зарчим алдагдах, эрх мэдлийн хэт төвлөрөл бий болох, ашиг сонирхлын зөрчил үүсэх, түүнчлэн төрийн захиргааны албан хаагч гүйцэтгэх болон төлөөлөх үүргийг давхар гүйцэтгэх нь Төрийн албаны тухай хуулийн зарчимд харшлах, төрийн албан хаагчийн хариуцлагын хязгаар тодорхой бус болох, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн шатны Засаг даргын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулах зэрэг сөрөг үр дагавартай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/60 дугаар зүйлийн 60.1.21 дахь заалт:

“60.1.21.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

2/62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт:

“62.1.13.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

3/63 дугаар зүйлийн 63.1.13 дахь заалт:

“63.1.13.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг:

“38.6.Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтын дугаарыг “60.1.22” гэж, 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтын дугаарыг “62.1.14” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.13 дахь заалтын дугаарыг “63.1.14” гэж, 63.1.14 дэх заалтын

дугаарыг "63.1.15" гэж, 63.1.15 дахь заалтын дугаарыг "63.1.16" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн "Тайлбар: -Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөх бөгөөд 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дүн гарах хүртэл аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан тушаал эрхэлж болно." гэсэн тайлбарыг хассугай:

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"26.1.18.Аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"35.3.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 15¹ дугаар зүйлийн 15^{1.4} дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"15^{1.4}. Эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбарын даргыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад гурваас доошгүй жил ажилласан ажилтнаас сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргын санал болгосноор эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга томилж, чөлөөлнө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"37.5. Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргатай зөвшилцөн дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.2. Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн даргыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга, улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн харьяалах төв, лаборатори, хүрээлэнгийн дарга томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"24.3. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"18.2.Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"26.2. Аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын газрын /хэлтэс/ даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2/ Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор томилж, чөлөөлөх;" хэнд санал болгосноор

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"77.5.Аймаг, нийслэлийн татварын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн татварын хэлстийн даргыг нийслэлийн татварын газрын даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"10/зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь тухайн шатны Засаг даргын санал болгосноор байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.5 дахь заалт нэмсүгэй:

"12.1.5.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх;"

2 дугаар зүйл. Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтыг хассугай:

"10.1.11.Сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх;"

3 дугаар зүйл. Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалтын дугаарыг "10.1.11" гэж, 10.1.13 дахь заалтын дугаарыг "10.1.12" гэж, 10.1.14 дэх заалтын дугаарыг "10.1.13" гэж, 10.1.15 дахь заалтын дугаарыг "10.1.14" гэж, 10.1.16 дахь заалтын дугаарыг "10.1.15" гэж, 10.1.17 дахь заалтын дугаарыг "10.1.16" гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь хэсгийн дугаарыг "12.1.6" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.1.14 дэх заалт нэмсүгэй:

"32.1.14. Засаг захиргааны тухайн нэгжийн онцгой байдлын байгууллагын даргыг дээд шатных нь байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлөх;"

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"30.1.14. онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжийн бүтэц, орон тоо, цалингийн санг тогтоох, алба хаагч болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх, орон нутгийн онцгой байдлын байгууллагын даргын санал болгосноор тухайн нэгжийн алба хаагч болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх;"

3 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.14 дэх заалтын дугаарыг "32.1.15" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹ дугаар зүйлийн 32¹.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"32¹.4.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог баталж, нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн даргыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор томилж, чөлөөлнө;"

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7.2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг цагдаагийн төв байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн даргыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор тус тус томилж, чөлөөлнө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"17.1.5.улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэгч, улсын байцаагч, ажилтан, албан хаагчдыг хуульд зааснаар томилж, чөлөөлөх бөгөөд орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн даргыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор, орон нутаг дахь улсын бүртгэгч, улсын байцаагчийг тухайн газар, хэлтсийн даргын санал оруулснаар хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэсэн судлаачид:

Г.Цагаанбаяр	Өмгөөллийн “Баяр энд Ока партнерс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, өмгөөлөгч, Хуульч, Япон улс, Фукуокагийн их сургууль, магистр, 2022
Ж.Содномдаржаа	Өмгөөллийн “ӨҮ ЭС ДИ Партнерс” ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч, Хуульч, МУИС-ийн ХЗС, бакалавр 2013
Г.Болормаа	НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF) зөвлөх, Нийгмийн Бодлогын Магистр, Австрали улсын Мельбурны Их Сургууль, 2022-2024
Ж.Алтансүх	Өмгөөллийн ӨҮ ЭС ДИ Партнерс ХХН-ийн өмгөөлөгч, Хуульч, МУИС-ийн ХЗС магистр 2016

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН1	
ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ТАЙЛАНГИЙН ТОВЧЛОЛ	1
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	2
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:	3
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:	4
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:	5
1.4. Монгол Улсын эрх зүйн орчин	6
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	15
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	33
ДӨРӨВ. АСУУДЛЫГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАМААР ЗОХИЦУУЛАХ ЭСЭХ ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	35
4.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	35
4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	35
4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө	35
4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	35
4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх. 35	
ТАВ. ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	36
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	38
ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	43
Ашигласан эх сурвалж	46
Хавсралт 1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө	47
Хавсралт 2. Эдийн засагт үзүүлэх нөлөө	50
Хавсралт 3. Нийгэмд үзүүлэх нөлөө	53
Хавсралт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө	56
Хавсралт 5. Орон нутгийн чиг үүрэг хууль тогтоомжид тусгагдсан байдал	57
Хавсралт 6. Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд ба засаг даргын бүрэн эрх	68
Хавсралт 7. Сайд нарын Засаг даргатай байгуулж буй нийтийн эрх зүйн гэрээ	81
Хавсралт 8. Засаг даргад томилгооны бүрэн эрх олгох шалгуур үзүүлэлт	1

ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОНХНС	Орон нутгийг хөгжүүлэх нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 01	Аймгийн засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд зарим агентлагийн даргыг томилох бүрэн эрхийг томилох эрх хэмжээтэй холбоотой зохицуулалтын хувилбарууд
Хүснэгт 02	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд томилох, чөлөөлөх, хариуцлага оногдуулах боломжтой агентлагууд
Хүснэгт 03	Хүний эрхэд үзүүлэх нөлөө
Хүснэгт 04	Эдийн засагт үзүүлэх нөлөө
Хүснэгт 05	Нийгэмд үзүүлэх нөлөө
Хүснэгт 06	Байгаль орчинд үзүүлэх нөлөө
Хүснэгт 07	Орон нутгийн чиг үүрэг хууль тогтоомжид тусгагдсан байдал
Хүснэгт 08	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд ба засаг даргын бүрэн эрх
Хүснэгт 09	Сайд нарын Засаг даргатай байгуулж буй нийтийн эрх зүйн гэрээ
Хүснэгт 10	Засаг даргад томилгооны бүрэн эрх олгох шалгуур үзүүлэлт

ТАЙЛАНГИЙН ТОВЧЛОЛ

Энэхүү үнэлгээг Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын санаачлагаар хэрэгжүүлж буй “Нутагтаа эзэн Монгол” хуулийн цогц шинэчлэлийн төслийн хүрээнд боловсрууллаа.

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно”. Тавин найм дугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” гэж тус тус тусгасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Уг хуулийн төслийг боловсруулахдаа Үндсэн хуулийн анхны үзэл баримтлалыг тодотгох, улмаар 2019 оны нэмэлт, өөрчлөлттэй уялдуулахаар тусгагдсан боловч дагалдах хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулаагүйн улмаас практикт хэрэгжихэд хүндрэл учирчээ. Тухайлбал, Үндсэн хуулиар тодорхойлсон Засаг даргад хамаарах “хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг”-ийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнх нь хувьд ногдуулаагүй, орон нутаг болон төв засгийн бүрэн эрх, чиг үүргийн давхардал, тодорхой бус байдлыг арилгахад чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ”. Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Засаглалын талаар баримтлах бодлогын 5.2-т заасан “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна”¹ гэсэн зорилтын дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулж, нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19, 20, 27 дугаар зүйлийн хэрэгжилт, түүнд тулгамдсан асуудлыг судалсан.² Судалгааны үр дүнд Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-19.1.5 дахь зүйл, заалтуудын хэрэгжилтийг үнэлэв. Үнэлгээгээр дээрх сонгосон зүйл, заалтуудын хэрэгжилт сул байна гэж дүгнэж байна. Учир нь энэ хууль болон өмнө хэрэгжиж байсан олон хууль тогтоомжуудад орон нутаг чиг үүргээ бие даан шийдвэрлэх зарчмыг тусгаж ирсэн боловч өнөөг хүртэл энэ зарчим хэрэгжихгүй байсаар байна.

Тухайлбал, уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т тусгасан “орон нутаг чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх” зарчмыг хангаагүй, орон нутаг нь төв засгаас хараат байсаар ирсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар

¹ “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”, 2020 он, <https://legalinfo.mn/mn/detail/15406>

² Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болон бусад олон хууль тогтоомжуудтай уялдаагүй, чиг үүргийн хувьд давхардсан зэрэг асуудал үүсэж байна. Иймээс судалгааны багийн зүгээс орон нутгийн чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид оновчтой хуваарилах, ялангуяа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нь хамтад нь шийдвэрлэх, мөн орон нутгийн чиг үүргийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн түүнчлэн тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, 27.4, 27.5 дахь заалтуудад дүн шинжилгээ хийж үзвэл, Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч тухайн орон нутагт буй орон нутгийн газар, хэлтсийн ажилтан, албан хаагч нарт хариуцлага тооцох эрх хэмжээ олгогдоогүй байна. Энэ нь Засаг дарга харьяалах орон нутагтаа захиргааны нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн бодлого үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Иймээс судалгааны багийн зүгээс энэ хуулийн 27 дугаар зүйлийн хэрэгжилт сул байна гэж үнэлж байна.

Иймд хууль тогтоогчид Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох хэсэгт Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх зохицуулалтыг хийж өгснөөр салбарын хуулиудаар тухайн салбарын орон нутаг дахь төрийн захиргааны байгууллагын удирдлагыг томилж, чөлөөлөх эрх зүйн орчин бүрдэхээр байна гэж судлаачдын зүгээс зөвлөмж хүргүүлж байна.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын 1992 онд батлагдсан Үндсэн хууль болон түүний Хавсралт хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргах /Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг/, мөн БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх асуудлыг тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэх /Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг/, хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан дуусгах /Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг/ зорилтыг хуульчлан тодорхойлсон. Улсын бага хурлын 1992 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах, АИХ-ын хоёрдугаар хуралдааны шийдвэрийг биелүүлэх талаар нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд заасны дагуу юуны өмнө төрийн байгууллагын шинэтгэлийг хийж төрийн болон орон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагуудыг шинэчлэн зохион байгуулах ажлын хүрээнд Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Засгийн газрын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Сонгуулийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна.³

Үүнээс хойш Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг 1992, 2006, 2020 онд тус тус батлан мөрдөж ирсэн байна. 1992 онд батлагдсан энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны дараа бүрэлдсэн шинэ парламентын хэлэлцсэн анхны хуулиудын нэг байжээ. Үндсэн хуулийн Хавсралт хуульд нутгийн удирдлагын шинэ тогтолцоог 1992 онд багтаан бүрдүүлнэ гэж заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах бүх нийтийн анхны сонгууль 1992 оны намар болж, Засаг дарга нарыг томилох, тэдгээрийн ажлын албадыг бүрдүүлэх ажил хийгджээ. Эдгээр шинэчлэл нь төрийн удирдлагын төвлөрсөн тогтолцоо буюу орон нутаг дахь Ардын Депутатуудын Хурал, түүний гүйцэтгэх захиргаа, нэг намын бодлогод түшиглэсэн удирдлагын бүтцийг халж Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нутгийн удирдлагын цоо шинэ тогтолцоог бий болгох зорилт агуулсан байна. Гэвч энэхүү хууль нь Үндсэн хуулийн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг оролцуулан 57, 58, 59, 60, 61, 62, 63 дугаар зүйл буюу нэг бүлгийн 7 зүйлийн 21 заалтыг үг үсгээр нь хуулбарласан, Үндсэн хуулийн заалтуудыг уг хууль дэлгэрүүлэн зохицуулж чадаагүй ажээ.⁴

Харин 2006 онд батлагдсан хуулийн тухайд 1/ Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр удирдлагын босоо тогтолцоо давамгайлж, эрх мэдлийн төвлөрөл нэмэгдсэнээр орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах бодлого алдагдахад хүрч байсан. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төр, төсвийн байгууллагууд, тэдгээрийн удирдлагуудыг үндсэнд нь төвөөс удирдан чиглүүлж, томилон ажиллуулж байгаа нь орон нутгийн удирдлага нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа төр, төсвийн байгууллага, тэдгээрийн боловсон хүчний үйл ажиллагаанд нөлөөлөх боломжийг хязгаарласан. 2/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудыг байнгын тогтмол ажиллагаатай болгох чиглэлээр Хурлын хуралдааны жилд хийх тооны доод хязгаарыг нэмэгдүүлэх, Тэргүүлэгчдийн эрх мэдлийг өргөтгөх, Засаг дарга болон бусад албан тушаалтнууд Хурлын Төлөөлөгчдийг ажлаас нь халах, чөлөөлөх, шилжүүлэх, өөрчлөх тохиолдолд саналаа тухайн шатны Хурлын

³ Ж.Амарсанаа нар, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл” сүүлийн 20 жилийн тойм, Нээлттэй нийгэм форум, УБ, 2010 он, 12 дахь тал.

⁴ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хувийн хэрэг, боть 1, УИХ-ын Тамгын газар. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019 он, 8 дахь тал.

Тэргүүлэгчдэд урьдчилан танилцуулж, зөвшилцсөн байх, Хурлын түр хороо, хэсгүүд байгуулж ажиллуулах зэрэг заалтуудыг нэмж тусгасан. 3/ Зохицуулалтын буюу процедурын шинжтэй, хуульд нарийвчлан тусгаагүй асуудлуудыг шийдвэрлэх талаар Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох, Төлөөлөгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татан үндэслэлийг тодруулах, хуралдааныг орхиж гарахыг хориглох, Хурлын Засаг даргыг томилох, огцруулах талаар бүрэн эрхийг тодотгох, Засаг даргыг томилох процедурыг тогтоох, Мөн Засаг дарга Хурлын шийдвэрт хориг тавих журмыг тодорхой болгох, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хооронд үүссэн маргааныг зохицуулах журмыг тодорхой болгох заалтуудыг тус тус нэмсэн. 4/ Нутгийн удирдлагын байгууллагууд болох ИТХ, Засаг даргаас Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагуудтай харилцах харилцаа, Хурал, Засаг даргын үйл ажиллагааны эрхийн баталгаа, хамгаалалтыг тодотгон авч үзэх заалтууд нэмэгдсэн. Түүнчлэн тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш 10 гаруй жилийн хэрэгжилт дээр үндэслэн боловсруулсан шинэчилсэн найруулга нь тухайн үеийн амьдралаас урган гарсан маргаантай асуудлуудыг нарийвчлан зохицуулжээ. 1990-ээд оны сүүл, 2000 оны эхнээс бий болсон эргэн төвлөрүүлэх хандлага, тухайлбал, 2002 онд батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн эрх мэдлийг ихээхэн хумьсан нөхцөл байдлыг залруулах оролдлогыг уг шинэчилсэн найруулгаар хийжээ.⁵

Үүний дараа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-ийг засаг захиргааны нэгж тус бүрээр нь ангилан тогтоосон бөгөөд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад нийт 24 чиг үүргийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахыг заасан бөгөөд аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд тухайн чиг үүргийг зааглаж хуваарилсан байна. Эдгээр чиг үүргийн тухайд тодорхой хууль, түүнийг дагаж гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн эрхлэн гүйцэтгэх чиг үүрэг боловч уг хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг “хэлбэр төдий” хийсэн талаар зарим судалгааны үр дүн гарчээ.⁶

Иймд уг Аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зохицуулалтыг 2019 онд баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн “Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн

⁵ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

(шинэчилсэн найруулга)-ийн хувийн хэрэг, боть 1, УИХ-ын Тамгын газар. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019, 8-9 дэх талаас дам эшлэв.

⁶ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019 он, 2 дахь тал.

Төлөөлөгчдийн хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн хурал байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэж тусгасан. Тавин найм дугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” гэж тус тус тусгасантай нийцүүлэн хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-ийг Үндсэн хуулийн эрх зүйн онол, үзэл баримтлалын үүднээс дүн шинжилгээ хийж, хуульд тусгайлан зохицуулалт оруулах шаардлагатай эсэх асуудал ба Төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд учирч буй асуудлыг нээн илрүүлэх, тухайлбал Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах агентлагуудын даргын томилгооны асуудлыг Засаг дарга томилох боломжтой эсэхэд дүгнэлт өгөх;

3.Хууль хэрэгжих хугацаанд практикт үүсээд буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, Мөн уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд үүсдэг бэрхшээлүүдийг даван туулах, төрийн байгууллагын зарим чиг үүргийг нийтэд ойлгомжтой болгох зорилгоор холбогдох өөрчлөлтүүдийг хийх;

4.Төрийн ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалтыг гадаадын зарим орнуудын харьцуулсан туршлагыг харгалзан судлах, мөн орон нутгийн төсөв, санхүүгийн бие даасан, хараат бус байдлыг хэрхэн хангаж байгаа талаар судалж бодлогын шийдэл дэвшүүлэх.

5. Энэ хүрээнд эрх ашиг, сонирхол хөндөгдөж буй этгээдүүдээс ирүүлсэн санал, холбогдох холбогдох тооцоо, социологийн судалгаа, дүгнэлт, зөвлөмж зэргийг судалж үзсэн болно.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж эхэлснээс хойш уг хуульд дагалдах хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг зохион байгуулсан (2022 оны 4 дүгээр сард зөвхөн нэр томьёо, ойлголтыг нийцүүлэн 146 хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулсан) гэх боловч өнгөрсөн хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиудад зөвхөн хэлбэрийн өөрчлөлт оруулсан байна гэж дүгнэжээ.⁷

Үүнээс үзвэл төрийн захиргааны төв байгууллагуудын зүгээс хуульд заасан орон нутгийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийн талаар нэгдсэн бодлогогүй, эрх мэдлийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх талаар бодитой алхам хийхгүй, холбогдох салбарын хууль тогтоомжид эрх мэдлийн төвлөрлийг сааруулах талаар санаачилга гаргахгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад нийт 24 чиг үүргийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахыг заасан боловч практикт энэ нь хэрэгжилт сул буюу 10 чиг үүрэгт

⁷ Я.Бямбаяр, Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа, Удирдлагын академи, УБ, 2023 он, 2-3 дахь тал.

хамаарах хууль тогтоомжийг өөрчилсөн байна.⁸ Үүнээс үүдэн төрийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлж буй бүх шатны Засаг дарга түүний эрх зүйн байдалд тодорхойгүй байдал үүсэж байна.

Иймд судалгааны багийн зүгээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхтэй холбоотойгоор аймгийн Засаг даргад зарим агентлагийн даргыг томилох эрх мэдлийг олгох талаар судална. Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байдлыг бэхжүүлж, төрийн захиргааны төв байгууллагаас агентлагийн даргыг томилж буй байдлыг халж төвлөрлийг сааруулах нь орон нутаг дахь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэж, төрийн байгууллагад хандан үйлчлүүлж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл бүрэлдэх ач холбогдолтой гэж үзэж байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн явцад дараах тулгамдсан асуудал үүсэж байна.

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд орон нутгийн 24 чиг үүргийг тоочих замаар тогтоосон боловч орон нутаг чиг үүргээ бие даан шийдвэрлэх зарчим өнөөг хүртэл хэрэгжихгүй байна. Тухайлбал, уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т тусгасан “орон нутаг чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх” зарчмыг хангаагүй, орон нутаг нь төрийн захиргааны төв байгууллагаас хараат байсаар ирсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болон бусад олон хууль тогтоомжуудтай уялдаагүй зэрэг асуудлууд гарч байна.

Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан “Орон нутгийн чиг үүрэг”-ийг салбарын бусад хуулиудад дэлгэрүүлэн тусгасан боловч эдгээр хуульд тусгасан чиг үүргийг бусад дагалдах хуулиар дэлгэрүүлэн хуульчлаагүй, хууль тогтоомж хоорондын уялдааг хангаагүй байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд холбогдох дараах тулгамдсан асуудал тулгарч байна. Өнөөгийн байдлаар орон нутагт 46 нэгж албан байгууллага болон хуулийн этгээд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж иржээ. Үүнээс 12 нэгж хуулийн этгээдийн удирдлагыг Засаг дарга, 34 байгууллагын удирдлагыг төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхийн төрийн захиргааны төв байгууллагаас томилж байна. Үүнээс үүдэн Засаг даргаас орон нутагтаа захиргааны нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн бодлого үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл үүссэн, мөн шат шатны Засаг дарга тухайн орон нутагт буй орон нутгийн газар, хэлтсийн ажилтан, албан хаагч нарт хариуцлага тооцох эрх хязгаарлагдмал сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Энэ нь иргэдэд төрийн үйлчилгээг нэгдсэн бөгөөд тэгш, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэжээ. Иймээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох заалтад дүн шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай гэж судалгааны багийн зүгээс үзэж байна.

⁸ Я.Бямбаяр, Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа, Удирдлагын академи, УБ, 2023 он, 264 дэх тал.

1.4.Монгол Улсын эрх зүйн орчин

МУЗЗНДНТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг ойлгоно хэмээн тодорхойлсон. Уг заалтаас үзвэл нутгийн өөрийн удирдлагын байгууллага буюу бүх шатны хурал, иргэд хуульд заасны дагуу хэнтэй ч үл хуваан, дангаар эрхлэн шийдвэрлэх нийгэм, эдийн засгийн асуудлыг орон нутгийн чиг үүрэгт хамааруулжээ.

Монгол Улсын хувьд орон нутаг тусгайлан олгосон чиг үүрэгтэй байх үзэл баримтлалыг Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгээр хүлээн зөвшөөрсөн. 2020 онд батлагдсан МУЗЗНДНТУТХ-ийн 20-26 дугаар зүйлд орон нутгийн чиг үүрэг, улмаар нэгж тус бүрийн хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоосон.

МУЗЗНДНТУТХ-ийн 19 дүгээр зүйлд хууль тогтоогч орон нутгийн чиг үүргийг тогтооход зайлшгүй баримтлах зарчмыг тусгайлан заасан бөгөөд орон нутгийн чиг үүргийг тогтоохдоо энэ зүйлд заасан зарчим бүрийг баримтлах үүрэгтэй юм.⁹

Монгол Улсын Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж тусгажээ. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хоёр шатлалд хуваагдаж байгаа буюу төв засгаас чиг үүрэг, өөрийн удирдлага, эдийн засгийн хувьд хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлж өгчээ. Үүнийг дэлгэрүүлэн авч үзвэл, Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг гэдэгт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-27 дугаар зүйлд тусгасан орон нутгийн чиг үүргийг ойлгоно.

Орон нутгийн өөрийн удирдлага гэдэг нь удирдлагын босоо түвшинд төв засгаас чиг үүргийн хувьд хараат бусаар буюу өөрийн эрх мэдлийн хүрээний асуудлыг бие даан шийдвэрлэх асуудлыг ойлгодог бол хэвтээ түвшинд иргэдийн хурал ба засаг дарга хоорондын чиг үүргийн хуваарилалтыг авч үздэг. Харин эдийн засаг, нийгмийн цогцолбор гэдэг нь өөрийн нутаг дэвсгэртээ тухайн орон нутгийн онцлогт нийцсэн эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх үүднээс төв засгаас ялгаатай төсөв, санхүү, татварын бодлого хэрэгжүүлэхийг ойлгоно.

Чиг үүрэг гэдэг нь тухайн субъектийн хувьд хуульд заасны дагуу заавал хэрэгжүүлэх үйлдэл, үйл ажиллагааг ойлгох бөгөөд нэг чиг үүргийг олон субъектийн дунд тодорхойлсноор ажил эзэнгүйдэх, хариуцлага алдагдах нөхцөл бий болдог. Уг судалгаанд хамаарах хэсэг буюу бүх шатны засаг даргын нийтлэг бүрэн эрхэд тухайн нутаг дэвсгэр дэх хөгжлийн төлөвлөлтийг удирдан зохион байгуулах, төсөв, санхүү, татварын бодлого хэрэгжүүлэх, хүн амд ерөнхий боловсрол олгох, эрүүл мэндийг хамгаалах, соёл урлаг, шинжлэх ухааныг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, соёл урлаг, шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль ёс, дэг журмыг сахиулах, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, гал түймэр, малын халдварт өвчин, байгалийн гэнэтийн аюултай тэмцэх, орон нутгийн Засаг захиргааны болон бусад шаардлагатай боловсон хүчин бэлтгэх зэрэг бараг бүх салбар чиглэлээр тодорхой үүрэг хүлээж, эрх эдэлж байна.

⁹Д.Сүнжид, А.Бямбажаргал, Н.Баярмаа, Г.Сурахбаяр, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа нарын бүрэлдэхүүнтэй, ННФ-ын санхүүжилтээр “Газрын хэвлийн баялаг ашиглахтай холбоотой Засгийн газар ба Орон нутгийн чиг үүргийн хуваарилалт, УБ, 2024 он, 29-30 дахь тал.

19.1.1.чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид болон зохих түвшинд оновчтой хуваарилах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн шинэчилсэн найруулгыг үзэл баримтлал, танилцуулгад орон нутгийн чиг үүргийг тодорхойлоод, уг чиг үүргийг орон нутаг бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй байх, чиг үүргийг аль болох иргэдэд ойр нэгжид хуваарилан, санхүүжилтийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх гэсэн үндсэн зарчмыг баримталсан байна.¹⁰

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэгт “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх” гэж Засгийн газарт үүрэг болгосны дагуу орон нутгийн нийт 24 чиг үүргийн 10 чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, тодорхой хэмжээний нийцүүлэх ажлыг хийсэн байна. Гэвч “нийцүүлэх ажил” нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд бус, системгүй, бүрэн бус, бусад хууль тогтоомжтой төдийлөн уялдаагүй, тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагуудын үзэмжээр хийсэн гэхээр байна гэжээ.¹¹

Тухайлбал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан “Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт”, “Орон нутгийн өмчийн удирдлага”, “Орон нутгийн сан”, “Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр”, “Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж”, “Орон сууц, нийтийн аж ахуй”, “Орон нутаг дахь нийтийн тээвэр”, “Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол”, “Гудамж, талбайн нэр, хаягжуулалт”, “Хөшөө дурсгалын зохицуулалт”, “Орон нутгийн аялал, жуулчлалын бодлого, менежмент”, “Орон нутгийн зам, гүүр” зэрэг чиг үүрэг нь орон нутгийн чиг үүрэгтэй зөрчилдөж, оновчтой зохицуулагдаж чадаагүй байна.¹² Үүнээс үзвэл энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын хэрэгжилт сул байгааг харуулж байна.

Мөн ярилцлагын аргаар хийсэн судалгааны үеэр чиг үүргийг орон нутагт хамгийн ойр нэгжид, оновчтой хуваарилах асуудал хэрэгжихгүй байгаа талаар оролцогчид түгээмэл дурдаж байв. Ялангуяа, орон нутгийн хувьд өдөр тутамдаа үйлчлүүлдэг, боловсрол, нийгмийн үйлчилгээний харьяа яам агентлагуудын удирдлагыг төрийн захиргааны төв байгууллагаас томилж буй өнөөгийн тогтолцоо нь орон нутгийн иргэдэд тулгамдаж буй асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх, онцлог хэрэгцээнд нь нийцүүлэхэд хүндрэл гарч байна.

Шигтгээ
...“Манай аймагт иргэдтэй өдөр тутамдаа хамгийн ойр ажилладаг нэгжийн нэг бол Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар байдаг. Гэвч тус газрын удирдлагыг манай орон

¹⁰ Я.Бямбаяр, Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа, Удирдлагын академи, УБ, 2023 он, 65 дахь тал.

¹¹ Мөн тэнд, 65 дахь тал.

¹² Мөн тэнд, 27-48 дахь тал.

нутгийн талаар ямар ч мэдээлэлгүй сайд томилж буй нь чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид хуваарилах асуудал хэрэгжихгүй байна”...

Говийн бүсийн төлөөлөл, Засаг даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

19.1.2. чиг үүрэг хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх

2021 онд Хүний хөгжил, судалгаа сургалтын төвөөс “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг Төсвийн тухай хуультай харьцуулсан судалгаа”-г хийж гүйцэтгэжээ. Уг судалгаагаар 2021 онд “Шинэчлэн баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө” агуулгаар судалгааг хийж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, тусгай зориулалтын шилжүүлэг, дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн хэмжээнд орох өөрчлөлт, түүний үр нөлөөг тооцох болон аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төсвийн төвлөрөл саарч, төсвийн бие даасан байдал нэмэгдэх эсэхийг шинжлэн дүгнэсэн байна. Уг судалгаанд төвлөрлийг сааруулах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд иргэнд хамгийн ойр нэгжид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг төсөв, санхүүгийнх нь хамт хуваарилж, үр дүнг тооцдог байх нь төсвийн хөрөнгийн үр ашиг, үр дүнг дээшлүүлэхэд эергээр нөлөөлөх ач холбогдолтой гэж дүгнэжээ.¹³

Төрөөс төвлөрлийг сааруулах чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулж, 2022 оноос эхлэн аймаг, нийслэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувьтай тэнцэх орлого нэмэгдсэн боловч сум, дүүрэг рүү 3 төрлийн татварын орлогоо шилжүүлж байна. Гэтэл орон нутгийн зарлагын чиг үүргүүдийг нь энэ хуулиар Төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэг болгож буцаагаад дээш нь буюу улсын төсөв рүү татахаар болсон. Төсвийн тооцоог хийж үзэхэд аль санхүүжилтийг нь яам болон орон нутаг хариуцах нь тодорхойгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна¹⁴ гэжээ.

Нөгөө талаар Засаг дарга нь төсвийн ерөнхийлөгч захирагч болохын хувьд шийдвэр гаргахдаа төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, Хуралд тайлагнах, татварын орлогыг төвлөрүүлэх, шилжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч Төсвийг захиран зарцуулах, хөрөнгө гаргах, санхүүжилт зөвшөөрөх шийдвэрүүддээ Засаг даргаас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрх (59.1.5; 60.1.5; 62.1.5; 63.1.5)-ээр бус, Төсвийн тухай хуульд заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх (14.2)-ийг үндэслэл болгох нь түгээмэл байна. Үүнээс гадна Сангийн сайдаас баталсан журам,

¹³ Хүний хөгжил сургалтын төв, “Шинэчлэн баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө”, УБ, 2021 он.

¹⁴ Л.Отгонтуяа нар, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтад хийсэн шинжилгээ, Удирдлагын академи, УБ, 2021 он, 71 дэх тал.

тушаал, шийдвэрийг үндэслэл болгох нь нийтлэг тохиолдож байна.¹⁵ Үүнээс дүгнэн үзвэл энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын практикт хэрэгжиж байгаа байдал хангалтгүй байгааг харуулж байна.

19.1.3. чиг үүргийг давхардуулахгүй байх

Засгийн газраас 2016 онд 350 дугаар тогтоол гаргаж “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ыг баталсан. Энэ баримт бичигт чиг үүргийг дахин хуваарилах аргачлал боловсруулж, түүний үндсэн дээр чиг үүргийг дахин хуваарилж төв засгийн газрын ачааллыг багасгаж орон нутгийн бие даасан байдлыг хангах зорилт тавьсан. Түүнээс гадна зарим чиг үүргийг хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх асуудлыг ч тусгасан байна. Гэвч энэхүү бодлогын баримт бичигт тусгасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт хэрхэн хуваарилсан эсэх асуудал тодорхойгүй байсан учраас Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах шаардлага бий болсон. Уг хуульд нутгийн удирдлага нь төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэхдээ дээд төвшний шууд удирдлагын дор үйл ажиллагаа явуулах ба харин орон нутгийн удирдлагын чиг үүрэгт хамаарах асуудлыг нутгийн удирдлагын бүрэн эрхэд хамааруулах зарчмыг баримтлах агуулгаар хуульд тусгагджээ. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан “Орон нутгийн чиг үүрэг”-ийг салбарын бусад хуулиудад дэлгэрүүлэн тусгасан байна.¹⁶ Гэвч эдгээр хуулиудад тусгасан чиг үүргийг бусад хуулиудаар дэлгэрүүлэн хуульчлаагүй, хууль тогтоомж хоорондын уялдааг хангаагүй байна.¹⁷

19.1.4. нэгжийн удирдлагад бүрэн эрх олгохдоо энэ хуулиар тогтоосон нэгж тус бүрийн чиг үүрэгт нийцүүлэн ялгаатай хуваарилах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд орон нутгийн 24 чиг үүргийг жагсаан тусгасан бөгөөд аймаг, сум, баг мөн нийслэл, дүүрэг, хорооны чиг үүргийг тус бүр ялгаатай байдлаар хуульчилжээ. Эдгээр нэгж тус бүрийн чиг үүргийг хуваарилахдаа Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг харгалзан тогтоох зарчмыг баримталсан байх ба нэгж тус бүрийн /21-26-д тусгагдсан чиг үүргүүд/ чиг үүргийг ялгаатай агуулгаар хуульчилжээ.

19.1.5. тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэх

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдаж, Засгийн газраас уг үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн. Энэхүү бодлогын шийдлийн үр дүнд тухайн орон нутгийн хүн амын эрэлт хэрэгцээ, байгаль орчны нөхцөл, онцлогт нийцсэн эдийн засгийн оновчтой бүтцийг бий болгох,

¹⁵ Я.Бямбаяр, Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа, Удирдлагын академи, УБ, 2023 он, 53 дахь тал.

¹⁶ Хавсралт 5-д тусгасан “Орон нутгийн чиг үүрэг хууль тогтоомжид тусгагдсан байдал” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁷ Энэ талаар уг судалгааны 1.4 дэх хэсгийн “Монгол Улсын эрх зүйн орчин” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

улмаар төрийн шат шатны нэгжийн чиг үүрэг, уялдаа холбоог хангахад чиглэсэн. Гэвч төв засгийн газар ба орон нутгийн чиг үүргийн ялгаа алдагдаж, Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын 47.6 хувь суурьшиж, ДНБ-ий 66.2 хувийг бүрдүүлэх болсон.¹⁸ Энэ нь төрөөс тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцсэн бодлогыг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Тухайлбал, баруун бүсэд эрчим хүчний тогтвортой эх үүсвэр бүрэлдээгүй, замын сүлжээ дутагдалтай, хувийн хэвшлийн тэргүүлэх аж ахуйн нэгж хөгжөөгүй, Хангайн бүсэд аялал жуулчлал, байгалийн нөөц ихтэй ч хойд, урд хөрштэй харьцах хилийн боомт, экспортын гарц багатай, Төвийн бүсэд газар тариалангийн бүс нутагт тооцогддог боловч олон улсын худалдаа, тээвэр ложистик сул, Зүүн бүсэд мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн нөөц ихтэй боловч эрчим хүч, дэд бүтцийн хөгжил сул хөгжсөн зэрэг нь төрөөс орон нутагт хэрэгжүүлэх бодлогыг ялгаатай байдлаар тодорхойлох шаардлагатай байгааг харуулж байна.

Гэвч шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай” хуульд энэ талаар нарийвчлан тусгаагүй бөгөөд тухайн орон нутгийн нэгж тус бүрийн чиг үүрэг, эрх хэмжээг ялгамжтай зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл, уг хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгэх” чиг үүргүүдийг жагсаан тодорхойлсон боловч хууль тогтоомжийн хувьд давхардсан, практикт хэрэгжих байдал сул байна. Мөн үүнээс гадна энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцахдаа талууд гэрээ байгуулж ажиллахаар тусгасан боловч гэрээнд тавигдах стандарт нөхцөл нэгэн хэвийн, хэрхэн хэрэгжсэн нь тодорхойгүй асуудал практикт үүсэж байна.

Шигтгээ
...“Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим албан тушаалтан, албан хаагч нарыг төв яамнаас шууд томилж байгаа нь ойлгомжгүй бөгөөд энэ албан тушаалтан хэний өмнө хариуцлага хүлээх нь тодорхойгүй, улмаар тухайн орон нутгийн асуудлыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг”... Засаг даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Түүнчлэн ярилцлагын судалгаанд оролцогчид орон нутагт төрийн чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгэх буюу орон нутагт чиг үүрэг нэмэгдсэн боловч дагалдах санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэхгүй орхигдуулах нь иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд хүндрэл учирдаг талаар түгээмэл дурдаж байв.

Үүнээс үзвэл энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-19.1.5 дахь зүйл, заалтуудын хэрэгжилтийг дараах байдлаар үнэлэв. Үнэлгээгээр дээрх сонгосон зүйл, заалтуудын хэрэгжилт сул байна гэж дүгнэж байна. Учир нь энэ хууль болон өмнө хэрэгжиж байсан олон хууль тогтоомжуудад орон нутаг чиг үүргээ бие даан шийдвэрлэх зарчмыг тусгаж ирсэн боловч өнөөг хүртэл энэ зарчим хэрэгжихгүй байсаар байна. Тухайлбал, уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т тусгасан “орон нутаг чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх” зарчмыг хангаагүй, орон нутаг нь төв засгаас хараат байсаар ирсэн. Мөн Монгол Улсын

¹⁸ Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, баримт бичиг, УБ, 2022 он.

Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болон бусад олон хууль тогтоомжуудтай уялдаагүй, чиг үүргийн хувьд давхардсан зэрэг асуудалтай холбоотой. Иймээс судалгааны багийн зүгээс орон нутгийн чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид оновчтой хуваарилах, ялангуяа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нь хамтад нь шийдвэрлэх, мөн орон нутгийн чиг үүргийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэхэд анхаарах шаардлагатай гэсэн зөвлөмжийг хүргүүлж байна.

Мөн үүнээс гадна Монгол Улсын хувьд дээр судалгаанд дурдсанчлан үе үеийн Засгийн газрын бодлогод орон нутгийн бие даан хөгжих боломжийг тэлэх, төвлөрлийг сааруулах чиглэлээр бодлого дэвшүүлж ирсэн боловч сүүлийн жилүүдэд төв засгийн газарт төрийн чиг үүргүүд, төсөв, томилгооны эрх мэдлийг төвлөрүүлсэн хууль тогтоомжуудыг баталж иржээ. Үүнээс үүдэн нутгийн өөрийн удирдлагыг Үндсэн хуульд тодорхойлсон зарчмаар хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх гол нөхцөл болох орон нутгийн өмч, татвар, төсөв санхүүгийн нөхцөл боломж зэрэг үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн үндэс төлөвшихөд сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Тухайлбал, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллахаар баталсан 30 агентлаг, байгууллагын 20 гаруй нь босоо удирдлагын тогтолцоотой, төсөв нь засгийн газраас санхүүжиж, удирдлагыг нь хариуцах сайд эсвэл төв газрын дарга томилж байна. Мөн орон нутгийн удирдлагад төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч, төрийн төлөөлөл болох шат шатны Засаг даргыг томилох, огцруулахдаа тухайн хурлын шийдвэр гэхээсээ эрх баригч намаас хэт хараат, Ерөнхий сайдын оролцоо нэмэгдэх хандлагатай байна.

Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн зарим санхүүжилтийн зарцуулалтыг хуульд тусгайлан зааснаар хөрөнгө оруулалтын чиглэлээр орон нутгийн шийдвэр гаргах эрхийг хязгаарласан, шилжүүлгийн дүрэм нь зарим талаар субъектив нөлөө орсон талаар шүүмжлэл дагуулж байна. Энэ нь аймгуудын хооронд эрх тэгш бус нөхцөл бий болгох, улмаар сум, дүүргийн хөгжлийн санд шилжих дүн нь 70 хувиас 40 хувь хүртэл буурах бодит нөхцөлийг бий болгож байна. Тухайлбал, Орон нутгийн хөгжлийн санд орох орлогоос импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын орлогын 5 хувийг хассан нь тус сангийн боломжит орлогыг ихээхэн хэмжээгээр бууруулсан. Мөн Татварын ерөнхий хуульд тус сангийн боломжит орлогыг ихээхэн хэмжээгээр бууруулсан. Мөн Татварын ерөнхий хуульд зааснаар УИХ-аас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан 11 төрлийн татварын хувь хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ болон хотын Зөвлөл батлах, 2 төрлийн татварын хувь хэмжээг сум, дүүргийн ИТХ, орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөл батлах эрхтэй байхаар заасан зэргийг дурдаж болно. Түүнчлэн практик амьдрал дээр үүнээс 4 төрлийн татварын хувь хэмжээг л аймаг, нийслэл эсвэл сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтоож байгаа нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын татварын орлогоо нэмэгдүүлэх эсвэл өөрийн онцлогт тохирсон бизнесийн орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах хөшүүрэг болж чадахгүй байна. Мөн үүнээс гадна улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгодог шилжүүлэг нь төвлөрсөн удирдлагатай салбаруудын хувьд орон нутаг өөрийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн зохицуулалт хийх боломжгүй байдаг тул боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт орон нутгийн тухайлсан бодлого хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

Эдгээр тулгамдсан асуудал нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд шийдэгдэхгүй явсаар өнөөг хүрсэн бөгөөд эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхойгүй байдал үүсгэсээр байна. Тухайлбал, Нээлттэй нийгэм форумас 2003 онд хэрэгжүүлсэн “Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал” судалгаанд нутгийн удирдлага болон Засгийн газар хоорондын харилцааны талаар дараах асуудлыг хөнджээ. Үүнд:

Бүх түвшний Засаг дарга нарын харилцаа нь баг хорооны Засаг дарга, сум, дүүргийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга Ерөнхий

сайдын өмнө хариуцлага хүлээж, ажлаа тайлагнадаг байдлаар тодорхойлогдоно.

Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог Засгийн газраас тогтоож өгдөг. Засаг даргын дэргэдэг яам, агентлаг нь Засаг даргатай зөвшилцөн томилж байгаа зэрэг нь Засаг дарга зохион байгуулалт, хүний нөөцийн асуудлаар Засгийн газраас хамааралтай ажилладаг болохыг харуулж байна.

Түүнчлэн яамд агентлагууд нь тушаал, шийдвэр гаргаад түүнийгээ орон нутгийн алба, хэлтсүүдээрээ дамжуулан хэрэгжүүлэх даалгавар өгдөг. Гэтэл уг асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө мөнгө орон нутгийн төсөвт тусгагдаагүй байдаг. Гэх мэтчилэн орон нутгийн байгууллагууд нь Засаг даргад тайлагнах, яаманд тайлагнах гэсэн хоёрдмол тогтолцоонд хамаарагдаж байна. Энэ мэт зөрчил зөвхөн төв Засгийн газар, аймгуудын хооронд гараад зогсохгүй аймаг сум болон сум багийн хооронд гарч байдаг.

Аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан орон нутгийн төрийн байгууллагууд нь яамд, агентлагтаа тайлагнадаг, хариуцлага хүлээдэг, боловсон хүчний асуудлаа шийддэг нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа нь зохион байгуулалтын хувьд буруу юм. Энэ байдлаас болж орон нутагт нэг талаас яамд, агентлагаас гаргасан шийдвэр, нөгөө талаас Засаг даргаас гаргасан шийдвэрүүд нь хоорондоо нийцэхгүй зөрчилтэй байгаа зэрэг нь удирдлагын тогтолцооны үр ашгийг бууруулдаг.¹⁹

Шигтгээ: ... Аймгийн засаг дарга

... “Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим албан тушаалтан, албан хаагч нарыг төв яамнаас шууд томилж байгаа нь ойлгомжгүй бөгөөд энэ албан тушаалтан хэний өмнө хариуцлага хүлээх нь тодорхойгүй, улмаар тухайн орон нутгийн асуудлыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг” гэжээ.

Түүнчлэн орон нутагт төрийн чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгэх буюу орон нутагт чиг үүрэг нэмэгдсэн боловч дагалдах санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэхгүй орхигдуулах нь иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд хүндрэл учирдаг.

Түүнчлэн “Орон нутагт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замууд (Нөхцөл байдлын судалгаа: Сэлэнгэ аймгийн

¹⁹ Л.Золзаяа, Л.Пувсанжамц нар, Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал, Нээлттэй нийгэм форум, УБ, 2003 он, 25 дахь тал.

жишээн дээр)” сэдэвт судалгааны тайланд уг судалгаанд хамааралтай дараах дүгнэлтийг тусгажээ.²⁰

Аймгийн Засаг дарга болон ИТХ-ын хуулиар хүлээсэн бүрэн эрхийн шинжилгээ: Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 723 хууль байгаагаас (136 нь хүчингүй болсонд тооцогдсон) хуульд нэг бүрчлэн шүүлт хийхэд аймгийн Засаг даргад 75 хуулиар, аймгийн ИТХ-д 37 хуулиар төсвийн талаарх эрх, үүргийг олгосон бөгөөд хуулиар тухайн харилцааг зохицуулсан үйл ажиллагааг явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлах, төсөвт тусгах, зарцуулах, аливаа арга хэмжээг төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч нэгж, алба, байгууллагыг байгуулах, үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах зэргээр хэрэгжүүлэхээр зүйл, заалтууд тусгагдсаныг хууль тус бүрээр түүвэр бэлтгэж хавсралтаар танилцуулсан байна.

Орон нутгийн төсөв ба төсөв хоорондын шинжилгээ: Монгол Улсын хууль тогтоох болон удирдах эрх мэдэл нь төв засгийн газартаа төвлөрсөн төрийн нэгдсэн тогтолцоотой улс учир орон нутагт эрх мэдлийг хэсэгчлэн шилжүүлсэн байна. Бараг бүх татварыг Засгийн газар тогтоодог тул орон нутаг шинээр татвар бий болгох эрхгүй. Олон улсын туршлагаас үзэхэд орон нутаг нь өөрийн орлогын талаар нэлээд эрх мэдэлтэй байдаг, учир нь тэд өөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхой сайн мэддэг тул шаардлагатай зохицуулалтыг хийж чаддаг. Одоогийн мөрдөгдөж буй хуулийн дагуу орон нутаг цөөн тооны татварын болон төлбөрийн хувь хэмжээг УИХ-аас тогтоосон хязгаарт багтаан тогтоох эрхтэй байна. Гэхдээ эдгээр татварын зарим нэг нь харьцангуй бага орлого төвлөрүүлдэг. Жишээлбэл, үл хөдлөх хөрөнгийн болон тээврийн хэрэгслийн татвар нийт орлогын дөрвөн хувийг, бусад төлбөр нь нэгээс бага хувийг бүрдүүлж байна.

Орон нутаг дахь хүний нөөцийн чиг үүрэг: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын томилгооны эрх зүйн үндэслэлээс дүгнэж үзвэл орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч аймгийн Засаг дарга нь 7 агентлагийн даргаас бусад агентлагийн дарга нарыг томилох эрх байхгүй байна. Мөн босоо удирдлагатай буюу дээд шатны байгууллагаас томилогддог агентлагуудаас зарим байгууллагын хувьд төрийн захиргааны албан хаагчдыг өөрөө томилж, чөлөөлөх эрх зүйн зохицуулалтгүй байдаг. Жишээлбэл, Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга улсын бүртгэгч нарыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын шийдвэрээр орон нутгийн албан хаагчид томилогдож, чөлөөлөгддөг байх. Өөрөөр хэлбэл, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах бодлого практикт эсрэгээрээ хэрэгжиж байгаагийн тодорхой илрэл гэж үзэж болохоор байна. Салбарын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар босоо тогтолцоог нэмэгдүүлж байгаа нь төвлөрлийг сааруулах биш төвлөрлийг бий болгож байна гэж дүгнэсэн байна.

Судалгааны багийн зүгээс ... аймгийн Засаг даргаас ярилцлага авахад дараах хариултыг өгснийг унишгчдад хүргэе.

²⁰ Л.Отгонтуяа нар, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтад хийсэн шинжилгээ, Удирдлагын академи, УБ, 2021, 23-24 дэх талаас дам эш татав.

Шигтгээ: ... Аймгийн засаг дарга

... "Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим албан тушаалтан, албан хаагч нарыг төв яамнаас шууд томилж байгаа нь орон нутагт ажиллаж байгаа газар, хэлтсүүдийн дарга нарт хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж байна.

... Засаг дарга харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудаа томилох, чөлөөлөх, хариуцлага тооцох эрхээ эдэлж, дээрээс ирсэн бодлогоо хэрэгжүүлээд явбал болж байгаа юм.

... Томилгоо дээд шатны төрийн захиргааны байгууллагаас байхаар хариуцлага тооцох боломж бага. Нөгөө хүмүүс ч засаг даргаас дэвшүүлж байгаа бодлогоос зөрөөд, зүгээр өдөр өнгөрөөх байдлаар ажиллаж, үр дүнгүй ажилладаг.

... УИХ хууль батлах үүрэгтэй, Засгийн газар хуулийн биелэлтийг хангах үүрэгтэй. Цаашид төсөв батлах процессийг илүү нарийн болгомоор байгаа юм. Бидний явуулсан саналын 3-ны нэг нь л хэрэгждэг бөгөөд орон нутгаас сонгогдсон гишүүд, Сангийн яамны зөрүүтэй байр сууринаас болоод орон нутагт шаардлагатай чухал ажил шийдэгдэхгүй орхигддог.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аймгийн Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх үүргийг хүлээж байна. Гэтэл тус хуулийн 27 дугаар зүйлд заасан 27 чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай төсвийн эх үүсвэр болон тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим агентлагийн даргыг томилох эрх хэмжээ хуулиар олгогдоогүй байгаа нь орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн Хавсралт 1-д заасан Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд заасны дагуу аймгийн Засаг дарга Нэгжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргыг томилох хэрэгцээ шаардлагыг тандан судалж, санал боловсруулна.

27 дугаар зүйлийн 27.1, 27.2,²¹ 27.3, 27.4, 27.5 дахь заалтуудын хэрэгжилт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад “орон нутгийн чиг үүрэг”-ийг засаг захиргааны нэгж тус бүрээр нь ангилан тогтоосон бөгөөд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгад нийт 24 чиг үүргийг орон нутгийн чиг үүрэгт хамаарахыг заасан бөгөөд аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороонд тухайн чиг үүргийг зааглаж хуваарилсан байна. Эдгээр чиг үүргийн тухайд тодорхой хууль, түүнийг дагаж гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн эрхлэн гүйцэтгэх чиг үүрэг боловч уг хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг “хэлбэр төдий” хийсэн талаар зарим судалгааны үр дүн гарчээ.²²

Монгол Улсад ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 30 гаруй жилийн хугацаанд Засгийн газраас төвлөрлийг сааруулах, нутгийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарч ирсэн боловч практикт хэрэгжилт хангалтгүй байсан талаар олон судалгаанд дурдагджээ. Эдгээрийг тоймлон хүргэвэл, 1/ Нутгийн өөрөө удирдах байгууллагын хүний нөөцийн хуваарилалт, мөн бүх шатны засаг даргын бүрэн эрх, чиг үүрэгтэй холбоотой, 2/ Орон нутгийн төсөв, санхүүжилтийн бие даасан байдалтай холбоотой байна.

Тухайлбал, Нээлттэй нийгэм форумаас 2003 онд хэрэгжүүлсэн “Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал” судалгаанд “Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим албан тушаалтан, албан хаагч нарыг төв яамнаас шууд томилж байгаа нь ойлгомжгүй бөгөөд

²¹ Энэхүү заалтын хэрэгжилтийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар, үнэлгээний тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

²² Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019 он, 2 дахь тал.

энэ албан тушаалтан хэний өмнө хариуцлага хүлээх нь тодорхойгүй, улмаар тухайн орон нутгийн асуудлыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг” гэжээ.²³

Өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн болон төрийн чиг үүргийн 46 нэгж хуулийн этгээдээс 12 нэгжийн удирдлагыг Засаг дарга томилж байна.²⁴ Үүнээс 34 нэгжийг нь төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхийн төрийн агентлагийн дарга томилж байна. Үүнийг дэлгэрүүлэн үзвэл, 1/Байгаль орчны газар; 2/Биеийн тамир, спортын газар; 3/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар; 4/Орон нутгийн өмчийн газар; 5/Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар; 6/Хүнс, хөдөө аж ахуйн газар; 7/Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай); 8/Худалдан авах ажиллагааны газар; 9/Архивын хэлтэс; 10/Авто тээврийн төв; 11/Ус суваг, нийтийн аж ахуйн газар; 12/Чуулга, драмын театр юм. Ингээд орон нутаг болон төрийн чиг үүргийг хэрэгжилтэд гарч буй тулгамдсан асуудлыг дор дэлгэрүүлэн авч үзье.

Шигтгээ

...“Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим албан тушаалтан, албан хаагч нарыг яамнаас шууд томилж байгаа нь орон нутагт ажиллаж байгаа газар, хэлтсүүдийн дарга нарт хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн Засаг дарга харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудаа томилох, чөлөөлөх, хариуцлага тооцох эрхээ эдэлж, дээрээс ирсэн бодлогоо хэрэгжүүлээд явбал болж байгаа юм. Томилгоо төрийн захиргааны байгууллагаас байхаар хариуцлага тооцох боломж бага. Нөгөө хүмүүс ч засаг даргаас дэвшүүлж байгаа бодлогоос зөрөөд, зүгээр өдөр өнгөрөөх байдлаар ажиллаж, үр дүнгүй ажилладаг.

Мөн УИХ хууль батлах үүрэгтэй, Засгийн газар хуулийн биелэлтийг хангах үүрэгтэй. Цаашид төсөв батлах процессыг илүү нарийн болгомоор байгаа юм. Бидний явуулсан саналын 3-ны нэг нь л хэрэгждэг бөгөөд орон нутгаас сонгогдсон гишүүд, Сангийн яамны зөрүүтэй байр сууринаас болоод орон нутагт шаардлагатай чухал ажил шийдэгдэхгүй орхигддог”...

Засаг даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Иймээс судалгааны багийн зүгээс Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-13.1.7-д заасан ангилалд хамаарах төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хийгээд төрөөс зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ болох хууль сахиулах ажиллагаанд хамаарах чиг үүргийн удирдлагыг тухайн төрийн захиргааны төв байгууллага болон Үндсэн хуульд заасан томилгооны процесс болоод холбогдох нарийвчилсан хуулиар томилох нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, Цэргийн штаб, дотоодын цэрэг, хилийн цэрэг, тагнуул, шүүх, прокурор, цагдаагийн газар (хэлтэс), шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (хэлтэс), Онцгой байдлын газар (хэлтэс), Гаалийн газар (хэлтэс) зэрэг байгууллагын газар, хэлтсийн удирдлагыг төрийн захиргааны төв байгууллагаас томилж чөлөөлөх нь зүйтэй.

²³ Мөн тэнд, 24-25 дахь тал.

²⁴ Аймгийн Засаг даргын бүрэн эрх, томилгоо, чиг үүргийн талаар Хавсралт 6-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

Мөн үүнээс гадна Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагын удирдлагууд болох Санхүүгийн Зохицуулах Хороо, Үндэсний Аудитын Газар, Монгол банк, Үндэсний Статистикийн Хороо, Сонгуулийн Ерөнхий Хороо, Авлигатай Тэмцэх Газар, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Төрийн Албаны Зөвлөл гэх мэт байгууллагын орон нутаг дахь салбарын газар, хэлтсийн удирдлагыг тухайн төрийн захиргааны төв байгууллагаас томилж, чөлөөлөх нь эдгээр байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь төрийн мэргэшсэн бөгөөд шинжлэх ухааны онцлог бүхий чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа салбарын нэгдмэл удирдлагатай байх нь зохистой бол Улсын бүртгэлийн байгууллагын газар (хэлтэс) нь хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой мэдээллийг хадгалах үүргийнхээ дагуу төрийн захиргааны төв байгууллагаас нэгдмэл удирдлагатай байх нь зохистой гэж үзэж байна.

Харин орон нутаг дахь Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Татварын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс зэргийн удирдлагыг тухайн орон нутгийн засаг дарга томилох нь төрийн үйлчилгээг иргэдэд ойр бөгөөд хүртээмжтэй хүргэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Эдгээр байгууллагын тухайд орон нутагт төрийн нийтлэг чиг үүргийг анхан шатны нэгжид хүргэхэд чухал ач холбогдолтой бөгөөд тухайн шатны Засаг даргын өөрийн бодлогоо хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл болдог байна.

Түүнчлэн, Засаг даргаас харьяа орон нутагт чиг үүргээ хэрэгжүүлэхэд өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог боловч холбогдох хуулиудад Засаг даргын эрх хэмжээнд харьяалах газар, хэлтсийн удирдлагуудын томилгоо хийх эрх хязгаарлагдмал байна. Тухайлбал,

Боловсролын газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Нэгжийн тухай хуулийн 27.5.2-т "сургуулийн өмнөх боловсрол", 27.5.3-т "ерөнхий боловсрол" чиг үүргийг нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр хуульчилсан. Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлд Аймгийн засаг дарга боловсролын асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрхийг жагсааж өгсөн ба үүнд харьяа нутаг дэвсгэртээ орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх, боловсрол сургалтын байгууллагын материаллаг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах, боловсрол сургалтын байгууллагын багш, ажилтанд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах зэрэг өргөн хүрээний эрх хэмжээ, чиг үүргийг хуульчилж өгсөн байна.

Түүнчлэн, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай 28 дугаар зүйлд нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг жагсааж өгч, үүнд нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага нь боловсролыг хөгжүүлэх орон нутгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхээр, төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дотуур байр, сургууль цэцэрлэгийн суралцахад таатай орчин нөхцөлөөр хангах зэрэг үүргийг хүлээсэн байна. Мөн тус хуулиар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах үүргийг хүлээхийн зэрэгцээ Нэгжийн тухай хуулийн 27.5.2, 27.5.3-т заасан үйлчилгээг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд эдгээр нөхцөлийг тусгайлан заахыг хуульд тусгаж өгсөн байна.

Үүнээс үзвэл, аймгийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар өргөн цар хүрээтэй чиг үүрэг, хариуцлагыг хүлээж байх бөгөөд Боловсролын газрын даргыг томилох бүрэн эрхтэй байх шаардлагатай байна. Боловсролын ерөнхий хуулийн 26.1.8-д “тухайн орон нутгийн боловсролын газрын дарга, удирдлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлж байгаа билээ.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар өргөн цар хүрээ бүхий чиг үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээдэг болох нь жил бүр Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Засаг даргын хооронд байгуулагддаг Хамтран ажиллах гэрээнээс харагдаж байна. Тодруулбал тус гэрээнд Засаг даргад боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг баримталж, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, тэдгээрт нийцүүлэн гаргасан зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг чанартай үр дүнтэй зохион байгуулах, хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа орон нутгийнхаа боловсролын чанар, хүртээмжийн асуудлыг хэлэлцүүлэх, түүний дагуу арга хэмжээ авах, боловсролын салбарын барилга байгууламжийн бүртгэлийг жил бүр шинэчлэх, ашиглалт хамгаалалтын талаарх мэдээллийг Боловсролын яаманд хагас жил тутамд хүргүүлж байх үүргийг хүлээлгэжээ.

Суралцагч, иргэнд тэгш, хүртээмжтэй чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хичээлийн жилийн бүтцийг мөрдөх, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх, бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх гэх мэт нийт 36 үүргийг, Боловсролын салбарт менежмент, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн байгууллагын хүний нөөцийн чадавх болон материаллаг орчныг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх, цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлөөр хангах, сургалтын байгууллагын эзэмшил газрын баталгааг хангах гэх мэт 25 үүргийг, Санхүү төслийн удирдлага хэрэгжилтийн чиглэлээр сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, хөрөнгө оруулалтын саналыг хүргүүлэх, төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжин ажиллах, холбогдох тооцоо судалгаа, үйл ажиллагааг зохион байгуулах гэх мэт нийт 6 чиг үүргийг тус тус хүлээлгэсэн байна. Үүнээс үзэхэд Хамтран ажиллах гэрээний үр дүнд Засаг дарга нь орон нутагтаа боловсролын асуудлаар мэргэжил арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангаж, өргөн цар хүрээг хамарсан үйл ажиллагааг нутаг дэвсгэрийнхээ хүрээнд эрхлэн гүйцэтгэж байгаа болох нь харагдана. Эндээс Нэгжийн тухай хуулийн 27.5.2, 27.5.3-т заасан чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага буюу Засаг даргаар гэрээний үндсэнд төлөөлүүлэн гүйцэтгүүлж байгаа болох нь харагдана.

Шигтгээ

Аймаг, орон нутагт санаачлагатай ажиллах хүн хэрэгтэй. Бид бол бодлого боловсруулах ажилд бол оролцохгүй, гэхдээ яг тухайн аймагт шаардлагатай, хэрэгцээтэй байгаа зүйлсийг олж мэдээд Боловсролын газартай хамтран ажилламаар байдаг. Боловсролын газартай хамтран ажиллахад хэцүү. Жишээлбэл, хөдөөгийн хүүхдүүд хэл муутайгаас болоод оюутан болохдоо хотын хүүхдүүдээс хоцроод эхэлдэг. Миний зүгээс Хөвсгөл аймагт Англи болон Герман хэлийг олгоё гэж зорьсон. Бүх англи хэлний багш нараа цуглуулж байгаад төсөл бичээд, Америкт багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хэлэлцсэн. Ийм зүйл хийе гээд бүтэн 6 сар ярилцаад ойлголцоогүй. Нэгдүгээрт дээрээс томилгоотой, хоёрдугаарт үзэл бодлын хувьд ялгаатай.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Нэгжийн тухай хуулийн 27.5.5-т "хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ", 27.5.6-д "нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах" чиг үүргийг нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр хуульчилсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлд хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтад "хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум хорооны хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэнэ хэмээн Засаг дарга, орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь хүүхэд хамгааллын байгууллагын гол оролцогч нь байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэгт аймгийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, хөгжлийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах үйл ажиллагаа, арга хэмжээг тусгаж биелэлтэд нь хяналт тавих бүрэн эрхийг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд олгосон байна.

Улмаар аймгийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, тухайн жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг тусгах, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тусламж, дэмжлэг үзүүлэх өргөн цар хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна. Түүнчлэн аймгийн засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй хууль зүйн хороог байгуулж ажиллах үүрэгтэй байна. Засаг дарга нь хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлж байгаа тул шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Нэгжийн тухай хуулийн 27.2-т зааснаар шийдвэрлэхээр хуулийн 52.4-т тусгаж өгчээ. Мөн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргад чиглэл өгч хуулийн хэрэгжилтийг хангуулах эрх хэмжээтэй байна.

Харин Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд аймгийн засаг даргын хүүхдийн эрхийг хангах талаар авах арга хэмжээг жагсааж, хүүхдийн эрхийг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, энэ талаар гаргасан санал санаачилгыг дэмжих, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнаж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байна.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиар аймгийн Засаг даргад хүүхэд хамгааллын чиглэлээр өргөн цар хүрээтэй чиг үүргийг олгосон байх тул Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргыг Засаг дарга томилох бүрэн эрхтэй байх шаардлагатай байх боловч Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35.3-т "Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө" гэж заасан нөхцөл байдалтай байна.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын асуудлаар жил бүр салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймгийн Засаг даргын хооронд эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх тухай гэрээ байгуулагдаж байна. Уг гэрээний зорилго нь Засаг дарга нь аймаг орон нутагтаа салбарын асуудлаар холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх, шуурхай удирдлагаар хангах, гэрээнд тусгасан үүргийг хэрэгжүүлэн түүний үр дүнг Сайдын өмнө хариуцахад чиглэж байна. Тодруулбал Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны болон хамтарсан

багийн үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгаж батлуулах, хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйл, 20¹ дүгээр зүйлийн 20^{1.1}, 20^{1.3}, 20^{1.7}, 20^{1.9}, 20^{1.10} дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, хүүхдийн хөгжилд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах, Олон нийтийн байцаагч ажиллуулах замаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүргүүдийг хэрэгжүүлэхээр байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.5, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 26 дугаар зүйлийн 26.5, 27 дугаар зүйлийн 27.7, 31 дүгээр зүйлийн 31.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2.7, 40.4, 40.6, 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.1.3 дахь заалтын хэрэгжилтийг тус тус хангахад "Хүүхэд хамгааллын бодлого"-ы сурталчлан таниулж салбар бүрт мөрдүүлэх, өнгөрсөн онуудад орон нутгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан, үрчлэгдсэн, эсхүл бүтэн өнчин болсон хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай үед хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, хурдан морины уралдаанч хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлж аюулгүй байдлыг ханган ажиллах, хүрээлэн буй орчинд хүүхдэд ээлтэй байдлаар засвар үйлчилгээ хийх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнээс үзэхэд Нэгжийн тухай хуулийн 27.5.5, 27.5.6-т заасан чиг үүргийн тодорхой хэсгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага буюу Засаг даргаар гэрээний үндсэнд төлөөлүүлэн гүйцэтгүүлж байгаа болох нь харагдана.

Шигтгээ

Анх аймгаасаа томилдог байсан. Харьяа байгууллагаа бүгдийг нь аймгийн удирдлага сонгодог байгаад, бодлогын чиглэл нь дээд байгууллагаасаа ирдэг байвал болж байгаа юм. Томилгоо дээшээ явчихаар болохгүй байна. Сумын засаг дарга Тамгийн газрын даргаа л томилно, тэрэн дотор байгаа захиргааны л хэдэн албан тушаал шийдэх боломжтой. Хариуцлага тооцох боломж бага. Нөгөө хүмүүс ч мөн зүгээр өдөр өнгөрөөж үр дүнгүй байдаг. Гэхдээ тэр нь бас удирдаж байгаа хүнээсээ болдог. Өөрсдөө эндээсээ томилвол илүү үр дүнтэй.

Мал эмнэлгийн газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Нэгжийн тухай хуулийн 27.5.14-т "мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, түүний гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ" чиг үүргийг нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр хуульчилсан. Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль 13 дугаар зүйлд улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймгийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батлахаар, халдварт өвчнийг оношлох, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх чиг үүргийг аймгийн засаг даргад олгож, хорио цээрийн дэглэм тогтоож, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хориглох, гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу байгуулсан мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тайлагнах бүрэн эрхийг хуулиар олгожээ.

Түүнчлэн, мал амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, хяналтад авах арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

Харин Малын генетик нөөцийн тухай хуульд зааснаар малын генетик нөөцийн үйл ажиллагааны батлагдсан үүлдэр, омгийн малын генетик нөөцийн биологийн ашигт шинж чанарыг бататгах, үржлийн ажлын ололтыг хянан баталгаажуулах, цөм сүргийг сайжруулах арга хэмжээний зардал, малын бэлчээрийг сайжруулах, хадлан тэжээл бэлтгэх, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээний зардал, малын генетик нөөцийн сурталчилгааны зардал зэргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилж өгчээ. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийг аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын мал үржлийн алба хариуцахаар байна. Мал эмнэлэг, малын генетик нөөцийн асуудлыг орон нутагт нэгтгэн зохион байгуулах боломжтой бөгөөд харилцан уялдаатай асуудал байж болох юм.

Дээрх хуулиудаас үзвэл аймгийн Засаг даргад мал эмнэлгийн газрын даргыг томилох эрх хэмжээг олгох боломжтой байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.2-д “энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилно гэж тусгасан байна.

Шигтгээ

Мал эмнэлгийн газар ах дүү хамаатан саднаараа мөнгө хувааж идсэн асуудал гарсан. аймгийн гаралтай УБ-т ажиллаж байгаа хүнийг би санал тавиад тухайн хүн ажиллахаар болсон. Хэдий би мал эмнэлгийн газраар яриулж байж тухайн залууг албан тушаалд тавьсан ч доор нь ажиллаж буй хүмүүс байнгын матаад, шоглосоор байгаад явуулсан.

Нийгмийн даатгалын газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.5-д “хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ” нь төрийн төлөөлүүлэн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарахаар тусгагдсан. Энэ хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үүргийг ... бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ хэмээн тусгажээ. Иймээс орон нутаг дахь Нийгмийн даатгалын газар, хэлтсийн удирдлагыг нийгмийн даатгалын газрын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилох нь төрийн төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг болох нь харагдаж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын асуудлаар жил бүр салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймгийн Засаг даргын хооронд эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх тухай гэрээ байгуулагдаж байна. Уг гэрээний зорилго нь Засаг дарга нь аймаг орон нутагтаа салбарын асуудлаар холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх, шуурхай удирдлагаар хангах, гэрээнд тусгасан үүргийг хэрэгжүүлэн түүний үр дүнг Сайдын өмнө хариуцахад чиглэж байна. Тодруулбал Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах

хүрээнд ажил олгогчийн хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавих, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүссэн бол түүнийг барагдуулах ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдагдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ийнхүү гэрээ байгуулах замаар чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь Нэгжийн тухай хуулийн 25.5.5-д заасан чиг үүргийг Засаг даргаар төлөөлүүлэн гүйцэтгүүлж буй хэлбэр мөн.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.8-д “соёлын үйлчилгээ”, 27.5.19-д “түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт” зэрэг нь тус тус төрийн төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарахаар байна. Энэ хүрээнд Соёлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Соёлын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ” гэж тусгасан. Түүнчлэн тус хуулийн 23 дугаар зүйлд Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд соёлын боловсрол олгох, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр баталж, хэрэгжилтийг хангуулах; Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, хөгжлийн хэтийн төлөв байдлыг тодорхойлж, хяналт тавих; Уран бүтээл туурвихад бүх талын дэмжлэг үзүүлэх гэж тусгасан бол 24 дүгээр зүйлд Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж тусгажээ. Тухайлбал, Орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, брэнд бий болгох, баяжуулан хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах; Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах; Аймаг, сум, нийслэл, дүүрэгт түүх, соёл, урлаг, эсхүл соёлын үнэт зүйлийг төлөөлж, илэрхийлэх соёлын орчин, орон зайг бүрдүүлж, хөгжүүлэх.

Түүнчлэн энэ хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-д “соёлын орчин, орон зайг бүрдүүлэх, хөгжүүлэх чиг үүргийг Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ. Иргэн, хуулийн этгээд соёлын орчин, орон зайг бий болгох, санал санаачилгыг гаргаж, тухайн шатны Засаг даргад уламжлан шийдвэрлүүлнэ, 30.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн онцлог бүхий соёлын орчин, орон зайг тодорхойлж, хот, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, батална. 30.4-т Түүх, урлаг, уран сайхны үнэт ач холбогдолтой, эсхүл өвөрмөц хийцтэй, үндэсний хэв загварыг хадгалсан салангид буюу цогцолбор барилга байгууламж, түүний тодорхой хэсэг, хөшөө, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээлийг хадгалж, хамгаална. 30.5-д Энэ хуулийн 30.4-т заасан барилга байгууламж, хөшөө, урлагийн бүтээлийн жагсаалтыг Засаг даргын санал, эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэх зэргээр тусгажээ.

Мөн үүнээс гадна 32 дугаар зүйлд соёлын үйл ажиллагааны санхүүжилтийг тусгасан байх бөгөөд соёлын үйл ажиллагааны төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хандив, соёлын байгууллагын төлбөртэй үйлчилгээ, дотоод, гадаадад зохион байгуулсан соёл, урлагийн арга

хэмжээнээс олсон орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ гэж тусгажээ.

Үүнээс үзвэл орон нутаг дахь иргэдийн төлөөлөгчдийн (нийтийн) хурал болон шат шатны засаг даргад соёлын талаар өргөн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд тусгажээ. Иймд Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн бүрэн эрхийн хүрээнд томилох нь төрийн төлөөлөн гүйцэтгэх чиг үүрэг болохыг харуулж байна.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Одоогоор аймгийн Засаг дарга нь Соёл, спорт, аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд салбарын сайдтай жил бүр төлөөлөх гүйцэтгүүлэх гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээнээс үүдэлтэй бүхий л үр дүнг салбарын сайдын өмнө хариуцна. Тухайлбал аймгийн Засаг дарга нь тус гэрээний үндсэнд орон нутгийнхаа хөгжлийн үндсэн чиглэлд батлагдсан соёл, урлаг, соёлын өв, биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудыг хөгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан эдийн засгийн эргэлтэд оруулах, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн хүн амыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, хүртээмжийг сайжруулах, жуучдын урсгалыг татах бүтээлч хотын хөгжлийн суурийг бэхжүүлэх, залуучуудын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, оролцоог дэмжих, төсвийн жилийн дундуур соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын байгууллагын орон тоо болон төсөв нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргахгүй байх, орон нутаг дахь салбарын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж тайлан мэдээг хүргүүлэх зэрэг томоохон хүрээний чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнээс үзэхэд Нэгжийн тухай хуулийн 27.5.8, 27.5.9, 27.5.19-т заасан чиг үүргийн тодорхой хэсгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага буюу Засаг даргаар гэрээний үндсэнд төлөөлүүлэн гүйцэтгүүлж байгаа болох нь харагдана.

Шигтгээ
...“Соёл урлаг, Биеийн тамир спортын газарт аймгийн бодлого салаад явж байгаа. Энэ зүйл суманд бас давтагдаж байна. Сумын засаг даргаа болиод аймгийн нийгмийн даатгалын газраа л дагадаг болсон. Боловсролын газрын дарга бол шууд сайд томилдог болсноос эхлээд зөрчил гарч эхэлж байна. Аймгийн газрын дарга ажил тасалсан Боловсролын газрын даргад хариуцлага тооцох боломжгүй. Орж ирээд загинахаас цаашгүй болсон. Зай хөндийрөөд, уулзаж учрахаа болиод ирэхээр холдоод ирж байна”... Засаг даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Татварын газар

Хуулиар шилжүүлж буй байдал: 2019 онд татварын харилцааны шинэчлэлийн хүрээнд Татварын багц хуулийг баталсан. Энэ хуулийн хүрээнд татварын хувь, хэмжээг Монгол Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгч Хурал, хотын Зөвлөл тогтоох эрхтэй байхаар тусгасан. Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 7.2.8, 7.2.13, 7.2.14, 7.2.16, 7.2.17, 7.2.20, 7.2.21, 7.2.24, 7.2.26, 7.2.28, 7.2.29-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл тогтоож болно” хэмээн хуульчилжээ.

Мөн үүнээс гадна Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тус тус тогтооно.

Аймаг, нийслэлийн засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ татварын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх; Хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ биелүүлэх явцад татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэл олж мэдсэн, илрүүлсэн бол уг мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх; Зөвшөөрлийн бүртгэл, өөрчлөлтийн мэдээлэл, нөөц хөрөнгө болон сангуудаас олгосон санхүүжилтийн мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх; Татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай бусад мэдээллээр татварын албыг хангаж, хамтран ажиллах гэх зэргээр тусгажээ.

Мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 21 дүгээр зүйлд “Албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл доор дурдсан хязгаарт багтаан тогтооно гэх зэргээ бүх шатны Засаг даргад татвартай холбоотой эрх үүрэг ногдуулсан байна. Иймд Засаг дарга тухайн орон нутагтаа төрийн бодлогыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх, улмаар тухайн орон нутагтаа төсөв, санхүүгийн хувьд үр ашигтай ажиллах ажлыг зохион байгуулах үүднээс Татварын газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн төрийн захиргааны төв байгууллага томилох шаардлагатай.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Засаг даргын Сангийн сайдтай байгуулдаг Хамтран ажиллах гэрээгээр Засаг даргад улсын болон орон нутгийн төсвийг цаг хугацаанд нь, татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх, НӨАТ-ийн буцаан олголтын урамшууллаас хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн татварын өртэй татвар төлөгчдийг өрөө суутган тооцуулах хүсэлт гаргах ажиллагааг орон нутагт идэвхжүүлэх, сургалт, сурталчигааг татварын албатай хамтран хэрэгжүүлэхүүргийг хүлээж байна.

Шигтгээ

Олон босоо томилогоонууд аймаг, сумын хариуцлагатай ажиллах боломжийг олгохгүй байна. Төрийн байгууллагууд хамтын ажиллагааны гэрээ байгуулж байгаа нь ойлгомжгүй, ямар зохицуулалтаар яах гэж байгуулаад байгааг ойлгодоггүй. Тэр нь үр дүн багатай. Босоо удирдлага их байгаагаас ажил явдаггүй, хариуцлага тооцох боломжгүй болдог. Жишээ нь аймгийн татварын еранхий газрын даргыг өөрчлөх гээд 3 жил хүсэлт гаргаад чадаагүй. Татварын хувь хэмжээ бол аймаг орон нутагт орлого бүрдүүлэх дээр чухал үүрэгтэй байдаг. Зарим үед татварын хувь хэмжээ, орлого бүрдүүлэлт сайтай байвал нэмэлт төсөв гарах боломжтой байдаг. Тэрийг тооцоод төсөвт оруулах дээр аймгийн удирдлагатай хамтран ажиллах шаардлагатай байдаг.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.5-д “хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ”, 27.5.6-д “нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах”, 27.5.7-д “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, түүний хэрэгжилт” гэж тус тус

төрийн төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг тусгасан. Энэ хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.4-т Энэ хуулийн 19.2.1-19.2.4-т заасан хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана.”, 27 дугаар зүйлийн 27.6-д “Амьжиргааг дэмжих Зөвлөлийн үйл ажиллагаанд сум, хорооны Засаг дарга, аймаг дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга хяналт тавьж ажиллана гэж тусгасан боловч нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг төрийн захиргааны төв байгууллагаас тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө гэж тусгасан. Үүнээс үзвэл хүн амд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх талаар Засаг даргад өргөн эрх хэмжээ, үүрэг хүлээлгэжээ. Иймд төрөөс нийгмийн халамжийн бодлогыг нэгдсэн байдлаар иргэдэд хүргэх, нөгөө талаар тухайн орон нутгийн онцогт тохируулах үүднээс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргыг тухайн шатны Засаг дарга томилох шаардлагатай.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын асуудлаар жил бүр салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймгийн Засаг даргын хооронд эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх тухай гэрээ байгуулагдаж байна. Уг гэрээний зорилго нь Засаг дарга нь аймаг орон нутагтаа салбарын асуудлаар холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх, шуурхай удирдлагаар хангах, гэрээнд тусгасан үүргийг хэрэгжүүлэн түүний үр дүнг Сайдын өмнө хариуцахад чиглэж байна. Тодруулбал Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 33 дугаар зүйлийн 33.1, 36 дугаар зүйлийн 36.1.3, 159 дүгээр зүйлийн 159.2 заалтын хэрэгжилтийн хүрээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хороо болон хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, аймаг сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих зэрэг чиг үүргийг хүлээнэ.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 25 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын статистик, мэдээлэл, бүртгэл, ажлын байрны захиалга зэрэг захиргааны мэдээний чанарыг сайжруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогод нийцэхгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ, иргэний судалгааг гаргах, зөвлөмж өгөх, орон нутагтаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих, орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөн хэрэгжүүлэх, орон нутгийн хөдөлмөрийн аюулгүй бадал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Мөн Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, олон хүүхэдтэй өрхийн амьжиргааг дэмжих үр дүнтэй арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнээс үзэхэд Нэгжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.6 болон 27.5.7 дахь хэсэгт заасан чиг үүргийг гэрээний үндсэнд Засаг дарга харьяа орон нутгийн хэмжээнд төлөөлөн гүйцэтгэж байгаа юм.

Шигтгээ
...“Манай аймагт иргэдтэй өдөр тутамдаа хамгийн ойр ажилладаг нэгжийн нэг бол Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар байдаг. Гэвч тус газрын удирдлагыг манай орон нутгийн талаар ямар ч мэдээлэлгүй сайд томилж буй нь чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид хуваарилах асуудал хэрэгжихгүй байна”... Засаг даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Шигтгээ
...“Хөдөлмөр халамж үйлчилгээний газар бол орон нутагт зайлшгүй хэвтээ удирдлагатай байх хэрэгтэй. Энийгээр дамжуулаад хөнгөлөлттэй зээл, жижиг дунд үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг. Босоо болчихоор улс төрийн байгууллага шиг болдог. Хариуцлага тооцож чаддаг бол хамгийн олон иргэд үйлчилгээ авдаг учир засаг дарга шууд нөлөөлөх боломжтой. Жишээ нь, Манай аймаг засаглал нь Ардчилсан намын засаглалтай, дээрээсээ ардын намын удирдлагтай. Гэтэл Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Засаг даргатай 2-хон удаа уулзсан”... ИТХ-ын даргатай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ.” гэжээ. Мөн түүнчлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т “тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх” гэж тусгасны дагуу уг хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-т “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” гэсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Иймээс тухайн орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн удирдлага, албан хаагчийг тухайн шатны Засаг даргын санал болгосноор Төрийн захиргааны төв байгууллага томилж, чөлөөлөх шаардлагатай.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймгийн Засаг даргын хооронд жил бүр байгуулагддаг Хамтран ажиллах гэрээгээр Засаг дарга нь эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллаж эрүүл мэндийн даатгалын

талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулах чиг үүргийг гэрээний үндсэнд хэрэгжүүлэхээр байна.

Гол мөрний ай сав газрын захиргаа

Хуулиар шилжүүлж буй байдал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-д “байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт”, 27.5.17-д “газрын харилцаа, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт” зэргээр төрийн төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг орон нутагт шилжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.5-д заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгагджээ. Үүнд:

1.Усыг хамгаалах, зохистой ашиглах, хуримтлуулах, нөхөн сэргээх, үерийн аюул, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх”,

2.Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах”,

3.Ус, усан орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах;

4.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах зэрэг чиг үүргийг хүлээжээ.

Үүнээс үзвэл Засаг дарга нь усыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар нэлээд өргөн бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа боловч Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн Гол мөрний ай сав газрын захиргааны удирдлагыг томилж, чөлөөлдөг байна. Энэ нь салбарын нэгдмэл бодлогыг хангах, мөн Засаг даргаас тухайн ажилтан, албан хаагчид хариуцлага оногдуулах боломжгүй байдалд сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй. Иймээс Засаг даргаас Гол мөрний ай сав газрын захиргааны удирдлага, албан хаагчийг томилох агуулгаар хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Одоогийн хуулийн дагуу байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Засаг дарга нь салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээнд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлсний үндсэнд түүнээс холбогдон гарах үр дүнг сайдын өмнө хариуцаж байгаа болно. Тус гэрээний нийтлэг үндэслэл хэсэгт талууд Байгаль орчны багц хуулиуд, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, МУЗЗНДНТУтХ, Ойн тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Төсвийн тухай ... зэрэг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллахаар заасан боловч Засаг даргын эрх үүргийн зохицуулалтад Усны тухай хуулийн зохицуулалттай холбоотой чиг үүрэг шилжүүлсэн хэсэг байхгүй байна.

Улсын тусгай хамгаалалттай газар

Хуулиар шилжүүлж буй байдал: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-д “байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт”, 27.5.17-д “газрын харилцаа, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт” зэргээр төрийн төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг орон нутагт шилжүүлэхээр

тусгасан. Энэ хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд Аймаг, нийслэлийн Засаг дарга 1/ Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 2/ Өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, хилийн заагийг тогтоох саналыг судалгаанд үндэслэн боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, хэлэлцүүлэх; 3/ Байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх; 4/ Байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг эрхлэх; 5/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах гэх мэтээр Засаг даргад өргөн бүрэн эрхийг олгожээ.

Мөн үүнээс гадна Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг дарга нь хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран энэ хуульд заасны дагуу орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.” гэж тусгажээ. Үүнээс үзвэл Засаг дарга орон нутагтаа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд заасан өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Иймээс Засаг дарга тухайн орон нутаг дахь Улсын тусгай хамгаалалттай газрын даргыг томилохдоо зохих шатны Засаг даргатай зөвшилцөн шийдвэрлэж, даргыг нь тухайн шатны Засаг даргын санал болгосноор байгаль орчны мэргэжилтэй албан хаагчийг томилох шаардлагатай.

Цахим хөгжлийн хэлтэс

Хуулиар шилжүүлж буй байдал: Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн шатны Засаг дарга харилцаа холбооны үйлчилгээг сайжруулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх”; 7.1.3-т “байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас харилцаа холбооны сүлжээг барьж байгуулах, сэргээн босгох, осол, гэмтлийг шуурхай арилгахад орон нутгийн бусад байгууллагыг татан оролцуулах, ажиллах хүч, техник хэрэгслээр хангах, шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зэрэг бүх талын дэмжлэг, туслалцааг үзүүлэх; 7.1.4-т “радио, телевизийн болон харилцаа холбооны бусад сүлжээ байгуулж, ашиглах санаачлагыг дэмжих, туслалцаа үзүүлэх”; 7.1.5-т “улсын төсвийн болон бусад хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөл хөтөлбөр, түүнчлэн тухайн орон нутгийн иргэдийн хүсэлтээр харилцаа холбооны шугам, сүлжээ байгуулах тохиолдолд бусдын эзэмшлийн газрыг харилцаа холбооны шугам, сүлжээний зориулалтаар үнэ төлбөргүй ашиглуулах ажлыг зохион байгуулах”; 7.1.6-д “харилцаа холбооны дэд бүтэц, шугам сүлжээ байгуулах газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулах” гэж тус тус Засаг даргад өргөн хүрээтэй үүрэг хүлээлгэсэн боловч орон нутаг дахь цахим хөгжлийн хэлтсийн удирдлагын төрийн захиргааны төв байгууллагаас томилж, чөлөөлж байна.

Гэрээгээр шилжүүлж буй байдал: Цахим хөгжлийн салбар дахь асуудлын хүрээнд Засаг дарга нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай жил бүр Хамтран ажиллах гэрээ байгуулж, түүний үндсэнд салбарын чиг үүргийг гэрээнд заасан хүрээгээр хэрэгжүүлдэг байна. Тодруулбал цахим засаглалыг бэхжүүлэх чиглэлээр төрийн үйлчилгээг цахимжуулах, оновчлох, загварчлах, нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох, камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн стандарт, нөхцөл шаардлагыг тодорхойлох судалгааг хийх, орон нутагт гарааны бизнес эрхлэх, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх сонирхолтой хүн, хуулийн этгээдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад холбогдох газар

нэгжээс нэгдсэн удирдамжийг авч хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, төрийн байгууллагын мэдээллийн системийг Үндэсний дата төвийн үүлэн системд шилжүүлэн байршуулж, давхардсан хөрөнгө оруулалт, мэдээллийн технологийн зардлыг бууруулах, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, нэгдсэн цахим хуудас www.gov.mn -д мэдээллээ байршуулж хэвших, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлээр дэвшилтэт технологийг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг олон нийтэд сурталчлан таниулах гэх мэт 21 төрлийн чиг үүргийг хүлээлгэжээ. Энэ нь гэрээний үндсэнд цахим хөгжлийн салбарын тодорхой чиг үүргийг Засаг даргаар гүйцэтгүүлж буй хэлбэр боловч энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан төлөөлүүлэн гүйцэтгүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байна. Энэ талаар уг судалгааны ганцаарчилсан ярилцлагад оролцогч ... Аймгийн Засаг дарга дараах агуулгаар шүүмжлэлтэй хандаж байсан.

Шигтгээ...

Аймгийн засаг дарга нар бүх зүйлийг хэрэгжүүлэх үүрэгтэй боловч шууд хариуцлага тооцох боломжгүй. Орон нутгийн ажил явдаггүйн том жишээ энэ байна. Жишээ нь, манай аймгийн цахим мэргэжилтэнг яам томилж байгаа. Яам томилоход өмнө нь шууд надад орж ирж тайлангаа ярьдаг байсан бол хамтран ажиллах боломж бага гээд үүнээс болоод үр дүн, үзүүлэлт буурсан.

Хүснэгт 2. Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд томилох, чөлөөлөх, хариуцлага оногдуулах боломжтой агентлагууд

№	Агентлагууд ²⁵	Холбогдох хуулийн заалт	Өөрчлөх санал
1	Боловсролын газар	Боловсролын Ерөнхий хууль: 26 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 26.1.18. аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;	Боловсролын Ерөнхий хууль: 26.1.18. аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;
2	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Хүүхэд хамгааллын тухай хууль: 35.3. Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан	Хүүхэд хамгааллын тухай хууль: 35.3. Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг

²⁵ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний 37-р тогтоол.

		төрийн захиргааны байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.	хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.
3	Мал эмнэлгийн газар	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль: 28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга;	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль: 28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга , аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга ;
4	Нийгмийн даатгалын газар	Нийгмийн даатгалын ерөнхий хууль: 37.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль: 37.5.Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн засаг дарга, дүүргийн нийгмийн даатгалын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргатай зөвшилцөн дүүргийн засаг дарга томилж, чөлөөлнө.
5	Соёл, урлаг, аялал жуулчлал,	Соёлын тухай хууль: 18.2.Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг, нийслэлийн Засаг даргатай	Соёлын тухай хууль 18.2. Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн

	залуучуудын газар	зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.	газрын гишүүнтэй зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.
6	Татварын газар	Татварын Ерөнхий хууль: 77.5. Аймаг, нийслэл, хот, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг дарга, хотын Захирагчтай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Татварын Ерөнхий хууль: 77.5. Аймаг, нийслэлийн татварын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн татварын хэлтсийн даргыг нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж нийслэлийн татварын газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.
7	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Нийгмийн халамжийн тухай хууль: 24.3. ... аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	Нийгмийн халамжийн тухай хууль: 24.3. ... аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.
8	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	Эрүүл мэндийн даатгалын тухай 151 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, түүний удирдлага 151.4. Эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбарын даргыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад гурваас доошгүй жил ажилласан ажилтнаас сонгон шалгаруулж, эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	Эрүүл мэндийн даатгалын тухай 151 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, түүний удирдлага 151.4. Эрүүл мэндийн даатгалын орон нутгийн салбарын даргыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад гурваас доошгүй жил ажилласан ажилтнаас сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргын санал

			болгосноор эрүүл мэндийн даатгалын байгууллагын дарга томилж, чөлөөлнө.
9	Гол мөрний ай сав газрын захиргаа	Усны тухай хууль 10.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны харилцааны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.11.сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх;	Усны тухай хууль 12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх. 12.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх
10	Улсын тусгай хамгаалалттай газар	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх. 10/ зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх. "10/ зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь тухайн шатны Засаг даргын санал болгосноор байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Хавсралт 1-д заасан аргачлалын дагуу зорилгод хүрэх байдал буюу “Төрийн буюу орон нутгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1.Аймгийн Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд зарим агентлагийн даргыг томилох эрх хэмжээтэй холбоотой зохицуулалтын хувилбарууд

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төв засгаас орон нутгийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим талаар байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Захиргааны шийдвэр гаргах	Төрийн болон орон нутгийн чиг үүргийг зохицуулсан дүрэм, журмыг орон нутгийн хэмжээнд шийдвэрлэж болох хэдий ч хууль хоорондын уялдаа холбоог хангахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хууль тогтоогчоос орон нутгийн эрх мэдлийг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах үүднээс Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн даргын томилгоог салбарын холбогдох нарийвчилсан хуулиар зохицуулж өгсөн байх тул тухайн хуулиудыг өөрчлөх замаар өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Тодорхой зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй
---	--------------------------------------	--	---	-----------

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодотгон хуульчлах үүднээс Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох заалтад аль эсвэл Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлагийн даргыг томилохтой холбоотой салбарын нарийвчилсан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Уг хууль боловсруулахтай уялдуулан Боловсролын ерөнхий хууль, Хүүхэд хамгааллын тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Соёлын өвийг хамгаалах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Статистикийн тухай, Татварын ерөнхий хууль, Ус цаг уур, орчны шинжилгээний тухай, Нийгмийн халамжийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ.АСУУДЛЫГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАМААР ЗОХИЦУУЛАХ ЭСЭХ ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Түргэн шуурхай, илүү ойлгомжтой бүртгэлийн үйлчилгээг иргэдэд санал болгох замаар Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эрх зүйн зохицуулалтын хувьд төрийн зарим чиг үүргийг хуулиар тодорхой зохицуулаагүй хэдий ч бүх шатны засаг дарга, иргэдийн хурлын практикт хийгддэг ажиллагаа учраас энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар эдийн засагт ачаалал үүсгэхгүй бөгөөд байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд зохицуулалт хийх байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор иргэд төрийн байгууллагаас түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ авахаас гадна төр болон орон нутгийн хооронд эрх зүйн хувьд шийдвэрлэгдээгүй асуудлууд тодорхой бөгөөд ойлгомжтой болно.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. Мөн уг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох үндэслэл, журмыг энэ хуулиар дэлгэрүүлэн зохицуулна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “орон нутгийн чиг үүргийг нэмэгдүүлж болно” гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хуулийн зарчим агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна.

ТАВ.ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны багийн зүгээс зохицуулалтын хувилбаруудыг харьцуулахын тулд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд тусгасан төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан агентлагуудад дүн шинжилгээ хийхдээ тухайн шатны Засаг даргад хуулиар ямар чиг үүрэг олгосон эсэхийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудаас түүвэрлэн судалсан. Мөн түүнчлэн Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудад орон нутгийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхэд санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэсэн эсэхийг төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн Засаг дарга хоорондын байгуулсан нийтийн эрх зүйн гэрээнд дүн шинжилгээ хийсэн болно. Мөн үүнээс гадна тухайн салбарын хуулиар төрийн захиргааны байгууллагын эрх зүйн байдал, ялангуяа удирдлага, зохион байгуулалт нь нэгдмэл бөгөөд төвлөрсөн эсэхийг судалж, улмаар судалгааны түүврийн дагуу орон нутгийн Засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч нартай хийсэн санал, асуулгыг ашигласан болно. Эдгээр шалгуур үзүүлэлтийг дор харуулав.²⁶

- 1.Нэгжийн тухай хуулиар төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэгт хамаарч байгаа эсэх;
- 2.Салбар салбарын нарийвчилсан хуулиар Засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн цар хүрээтэй чиг үүрэг олгосон эсэх;
- 3.Чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийг орон нутаг хариуцахаар хуульд заасан эсэх;
- 4.Засаг дарга болон Яамдын сайд нарын хооронд байгуулсан гэрээгээр чиг үүргийг шилжүүлж буй байдал;
- 5.Ярилцлагын судалгааны санал;
- 6.Тухайн салбарын хуулиар Удирдлага, бүтэц зохион байгуулалт нь нэгдмэл төвлөрсөн байх шаардлага, хараат бус бие даан үйл ажиллагаа явуулах шаардлага зэргийг харгалзан үзэх.

Дээр дурдсан 6 шалгуур үзүүлэлтээр шалгаж үзээд дараах гурван бодлогын хувилбарыг дэвшүүлж байна.

- 1.Засаг даргын санал болгосноор эсхүл зөвшилцсөний дагуу төрийн захиргааны төв байгууллага томилох боломжтой байгууллагууд

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Татварын газар, Улсын тусгай хамгаалалттай газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд тусгасан төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр холбогдох хуульд тусгагдсан боловч Засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад хуулиар өргөн чиг үүрэг олгогдсон, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийг орон нутагт тусгайлан тогтоосон байдал, орон нутаг дахь агентлагийн нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зэрэг онцлог шинжээс нь хамааруулан “Засаг даргын санал болгосноор эсхүл зөвшилцсөний дагуу төрийн захиргааны төв байгууллага томилох” гэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

- 2.Төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор эсхүл зөвшилцсөнөөр тухайн шатны Засаг дарга томилох, чөлөөлөх боломжтой байгууллагууд

Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Гол мөрний ай сав газрын захиргаа нь 1/ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд тусгасан төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр холбогдох хуульд тусгагдсан байдал; 2/ Салбарын нарийвчилсан

²⁶ Энэхүү хэсгийг дэлгэрүүлэн үзэхийг хүсвэл уг судалгааны Хавсралт 8-д тусгасан Засаг даргад томилгооны бүрэн эрх олгох шалгуур үзүүлэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

хуулиар Засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн цар хүрээтэй чиг үүрэг олгогдсон; 3/ Тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийг орон нутаг хариуцахаар хуульд тусгасан; 4/ Засаг дарга болон төрийн захиргааны төв байгууллагын хооронд байгуулсан нийтийн эрх зүйн гэрээгээр чиг үүргийг шилжүүлэн тусгасан; 5/ Уг судалгааны социологийн судалгааны үр дүн зэрэг шалгуур үзүүлэлтээр “төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор эсхүл зөвшилцсөнөөр тухайн шатны Засаг дарга томилох, чөлөөлөх” агуулгаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

3.Засаг дарга дангаар томилох боломжтой байгууллагууд

Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд тусгасан төлөөлөн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр холбогдох хуульд тусгагдсан байдал; Салбарын нарийвчилсан хуулиар Засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн цар хүрээтэй чиг үүрэг олгосон эсэх; Чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийг орон нутаг хариуцахаар хуульд заасан эсэх; Засаг дарга болон Яамдын сайд нарын хооронд байгуулсан гэрээгээр чиг үүргийг шилжүүлж буй байдал; Тухайн салбарын хуулиар Удирдлага, бүтэц зохион байгуулалт нь нэгдмэл төвлөрсөн байх шаардлага, хараат бус бие даан үйл ажиллагаа явуулах шаардлага; Ярилцлагын судалгааны санал, асуулга зэрэг бүх шалгуур, үзүүлэлтийг зэрэг хангаж байгаа учраас Засаг дарга эдгээр байгууллагын удирдлагыг дангаар томилох нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд судалгааны багийн зүгээс дээр дурдсан бодлогын хувилбаруудыг харгалзан үзэж тус хуулийн холбогдох хэсэгт Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Одоогийн нөхцөл байдалд аймгийн Засаг дарга зарим харьяа агентлагын даргыг томилж, чөлөөлж байгаа боловч Нэгжийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан бүрэн эрхээд ийм бүрэн эрх олгоогүй; хуулийн 60.1.20 дугаар зүйлд зөвхөн “аймгийн Засаг даргын орлогч, тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах” эрхтэй байхаар томьёолсон нь бусад харьяа агентлагын даргыг томилох, чөлөөлөх эрхгүй мэт нөхцөл байдалтай байна.

Засаг даргад томилгооны чиг үүргийг олгосноос үүсэх сөрөг үр дагаврыг хязгаарлах боломж

Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын даргыг Засаг дарга дангаар томилж, чөлөөлөх бүрэн эрхийг олгосноор Үндсэн хууль болон МУЗЗНДНТУТХ-д заасан орон нутаг нь тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх боломж нь илүү бүрдэх бөгөөд ажлын уялдаа холбоо хангагдаж, түргэн шуурхай ажиллах, агентлагийн дарга болон Засаг даргын хоорондын үл ойлголцох асуудал багасах, Засаг дарга өөрийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж болон төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх, хариуцлага тооцох, яамдын сайд нартай байгуулж буй гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломж нь нэмэгдэх, нэг баг болж хамтран ажиллах нөхцөл боломж нь илүүтэй бүрдэхээр байна.

Нэгэнт хуулиар орон нутгийн нэгжийн удирдлагад төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхээр заасан, үүний дагуу бүх яамдын сайд нар засаг даргатай гэрээ байгуулж нийт 19 сайдтай 652 тооны (2025 онд байгуулсан төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, хамтран ажиллах гэрээгээр. Хавсралт 7-оос дэлгэрүүлэн үзнэ үү) ажлыг хэрэгжүүлэхээр үүрэг хүлээн ажиллаж байна. Ийм чиг үүргийг гэрээгээр шилжүүлэн авч ажиллаж байгаа бол өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргатай нэг баг болж хамтран ажиллаж, орон нутгийн чиг үүрэг болоод төрийн чиг үүргийг саадгүй гүйцэтгэж байх шаардлагатай гэж үзэж байна.

Харин Засаг даргад агентлагийн даргыг дангаар томилох болон төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилох томилгооны эрх мэдлийг олгосноор ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн томилгоо хийх эрсдэлийг дараах арга замаар хянах, хязгаарлах боломжтой гэж үзэж байна.

Нэгдүгээрт. Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн хүрээнд хуульд заасан шаардлага хангаж байгаа хүнийг Засаг дарга томилж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох аудит хийх, үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн хүнийг эргүүлэн томилуулах шийдвэр гаргах зэргээр чадахуйн зарчмын хэрэгжилт болон Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах боломжтой байна.

Хоёрдугаарт. Хууль бусаар ажлаас чөлөөлөгдсөн хүн Төрийн албаны тухай хууль болон Захиргааны хэргийн шүүхэд хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой байна.

Гуравдугаарт. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг, 22.9 дүгээр зүйлд Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргүүдийг хуульчилсан байх бөгөөд Засаг дарга өөрт олгогдсон томилгооны эрх мэдлээ урвуулан ашиглаж, илт хууль бус томилгоо хийсэн, улмаар бусдад цалин хөлс олгосон зэрэг үйлдлүүд нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй бөгөөд эрүүгийн хуулиар тодорхой хэмжээний хамгаалалт, хязгаарлалтыг хийж өгчээ. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг нь Авлигатай тэмцэх газарт байгаа.

Дөрөв. Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх боломжтой байх бөгөөд эдгээр аудит, хяналт шалгалтын дүнд хууль бус томилгооны зөрчил илрэх боломжтой байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улсад ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 30 гаруй жилийн хугацаанд Засгийн газраас төвлөрлийг сааруулах, нутгийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарч ирсэн боловч үүний хэрэгжилт хангалтгүй байсан талаар олон судалгаанд дурдагджээ.

Үүнээс жишээ болгон дурдвал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ (2019) судалгаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд тууштай бус, амлалт төдий байсан²⁷ гэж дүгнэжээ. Уг судалгаанд дурдсанаар 2008-2012 онд “Засаг захиргааны нэгжүүдийг эдийн засгийн хувьд бие даан хөгжих бололцоогоор хангана; Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, эрх мэдлийн зохистой харьцааг тогтоон, нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлнэ.”, 2012-2016 онд “Төсөв, санхүү, боловсон хүчний томилгоотой холбоотой орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах”, 2016-2020 онд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно”

²⁷ УИХТГ, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019 он, 16 дахь тал.

гэж тусгасан боловч үе үеийн Засгийн газрын шийдвэрүүд үүнийхээ эсрэг байсан²⁸ хэмээн дүгнэжээ.

Иймээс судалгааны энэ хэсэгт төрийн төв болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг тогтоох шалгуур үзүүлэлт, харилцан хамаарлын талаар харьцуулсан судалгааны үүднээс товч дүн шинжилгээ хийнэ.

Гадаад орнуудын харьцуулсан туршлага

Европын Холбооны судлаачдын хэрэглэсэн арга зүйн хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үүрэг, хариуцлагыг хуваарилахад баримталдаг зарчмуудын агуулгыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:²⁹

- *Нутгийн өөрийн удирдлагын зарчим:* Өөрийн удирдлагыг орон нутгийн үйл ажиллагааны үндсэн зарчим буюу ардчилсан механизм гэж үздэг. Нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартийн 2 дугаар зүйлд “Орон нутгийн өөрийн удирдлагын зарчмыг дотоодын хууль, боломжтой нөхцөлд Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрнө” гэж заасан байдаг. Үндсэн хууль, бусад хууль, тогтоомжид орон нутгийн бие даасан байдал, орон нутгийн удирдлагын улс төрийн хүрээний зохицуулалтыг багтаана (өөрөөр хэлбэл, дээд газраас хяналт тавих арга хэрэгслээр хязгаарлагдахгүй хариуцлагын хүрээг хамруулна).

- *Субсидиар зарчим:* Энэхүү зарчим нь иргэнд хамгийн ойр эрх бүхий байгууллагууд эрх мэдлээ хэрэгжүүлэхэд давуу эрх олгох тухай агуулгыг илэрхийлдэг. Нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн чиг үүргийг аль болох иргэнд хамгийн ойр захиргааны нэгж хэрэгжүүлнэ. Аль нэг чиг үүргийг бусад эрх барих байгууллагад шилжүүлэхдээ тухайн ажлын хэмжээ, шинж байдал, үр ашигтай, хэмнэлттэй байх шаардлагыг харгалзан үзэх ёстой” гэж заажээ. Хамтран хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхдээ иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвартай, иргэдэд хамгийн ойр байгаа түвшинг сонгох хэрэгтэй байдаг.

- *Эрх мэдэл шилжүүлэх (төлөөлүүлэх):* Төв, орон нутгийн харилцаа нь төрийн төв байгууллагаас эрх мэдлээ орон нутгийн түвшинд шилжүүлэх, төлөөлүүлэх байдлаар илрэх ба хууль, тогтоомжийн дагуу шилжүүлсэн эрх мэдлийг хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх механизм, мэдээлэл дамжуулах урсгалыг тогтоох байдлаар зохицуулдаг. Нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Аливаа захиргааны хяналт нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны зөвхөн хууль, Үндсэн хуулийн зарчимд нийцсэн байдлыг хангахад чиглэнэ. Гэхдээ дээд шатны эрх барих байгууллагаас нутгийн өөрөө удирдах байгууллагад шилжүүлсэн үүргийн хэрэгжилтэд захиргааны хяналт хийгдэнэ” гэж тусгажээ.

Санхүүгийн хүрэлцээ: Санхүүгийн зохицуулалт нь эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн удирдлагад орлого олох боломж олгосон (орон нутгийн татвар, санхүүгийн дэмжлэг шилжүүлэг, бусад орлого) байдал, түүний хэрэгжилт, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн хамтын ажиллагаа, хуваарилалтын зарчим, санхүүгийн хүртээмжийг баталгаажуулах, орон нутгийн орлогын зөрүүг зохицуулах (хэт их зөрүү гарахаас сэргийлэх) гэх мэтийг илэрхийлдэг.³⁰

²⁸ Мөн тэнд, 17 дахь тал.

²⁹ Л.Отгонтуяа нар, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтад хийсэн шинжилгээ, Удирдлагын академи, УБ, 2021, 14 дэх тал.

³⁰ Л.Отгонтуяа нар, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтад хийсэн шинжилгээ, Удирдлагын академи, УБ, 2021, 14 дэх тал.

Эдгээр зарчмын хүрээнд дэлхийн зарим орны төв орон нутгийн чиг үүргийн хуваарилалтыг үзвэл орон нутагт иргэний бүртгэл, төрөөс олгодог тэтгэмж, иргэний хамгаалал, дэд бүтцийн хамгаалал гэх мэт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үйлчилгээний чанартай дараах нийтлэг чиг үүрэг гүйцэтгэж байна. Үүнд: Төлөвлөлт, Суурь боловсрол, Соёлын үйлчилгээ, Нийгмийн суурь хангамж, Эрүүл мэндийн суурь үйлчилгээ, Ус хангамж, Цахилгаан хангамж, Нийтийн тээвэр, Бизнесийг дэмжих гэх мэт юм.³¹ Ингээд төв ба орон нутгийн анхан шатны чиг үүргийг хэрхэн хуваарилсан талаар Польш, Чех, Дани, Албани, Болгар Улсаар тус тус жишээ болгон авч үзье.

Польш Улс³²

- Техникийн дэд бүтэц: Бохир, цэвэр усны сүлжээ, бохир усны цэвэрлэгээ, орон нутгийн зам, хог хаягдал, ус хангамж, ус хэмнэхэд чиглэсэн үйл ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдал, орон нутгийн нийтийн тээвэр, зах, худалдааны төвүүд.
- Нийгмийн дэд бүтэц: Боловсрол (ясли, цэцэрлэг, бага сургууль, гимнази), сургуулийн барилга, туслах барилгууд (биеийн тамирын заал), багшийн цалин.
- Эрүүл мэндийн алба: Эрүүл мэндийн суурь үйлчилгээ (өрхийн эмнэлэг), нийгмийн тусламж/халамж, асрамжийн төв, яаралтай тусламж, байнгын болон яаралтай мөнгөн тусламж.
- Соёл, биеийн тамир: Театр, соёлын төв, номын сан, аялал жуулчлал, спортын сайн дурын арга хэмжээг дэмжих, тоглоомын талбай, биеийн тамирын талбай, сургуулийн хичээлээс гадуурх ажлын зохион байгуулалт, дугуйн зам, аяллын зам.
- Гэр бүлийн бодлого: Жирэмсэн эмэгтэйчүүдийг халамжлах (эмнэлэг, эрх зүй, нийгмийн халамжаар хангах), сургуулийн аялал зугаалга, олон хүүхэдтэй айлд зориулсан нийгмийн орон сууц барих.
- Хэв журам, аюулгүй байдал: Галын болон үерийн аюулаас хамгаалах (сайн дурын гал команд)
- Цагдаа: Цагдаагийн илүү орон тоог татаас олгох, цагдаагийн тоног хэрэгсэлд татаас олгох
- Өөрийн харьяа байгууллага байгуулах: Хотын харуул хамгаалалт
- Хотын цэвэрлэгээ
- Нийтийн хэрэглээний аж ахуйг тордох: Хот, нийтийн аж ахуйг ашиглах дүрэм журам гаргах
- Нутаг дэвсгэрийн төлөвлөлт
- Орон нутгийн үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах
- Байгаль, орчныг хамгаалах
- Усны аж ахуй: Хэмнэлттэй зарцуулах бодлого, эх булаг хайх, усны сав газрыг хамгаалах, тордох.
- Цэцэрлэгт хүрээлэн, моджуулах
- ТББ-тай харилцах, өөрөө удирдах ёсны үзэл санааг дэлгэрүүлэх

³¹ А.Цанжид, Төв орон нутгийн харилцаа, чиг үүргийн зохистой хуваарилалт, Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, Конрад-Аденауэр-Сан, УБ, 2017 он, 32 дахь тал.

³²Мөн тэнд, 23 дахь тал.

Чех улс³³

- Хотын төсөв
- Орон нутгийн хөгжил
- Газар тариалан болон ойн аж ахуйн удирдлага
- Орон нутгийн цагдаа
- Усан хангамж болон бохир ус
- Өрхийн хог хаягдал
- Анхан шатны боловсрол
- Орон сууцжуулалт
- Социаль үйлчилгээнүүд
- Орон зайн төлөвлөлт
- Бусад нэгжүүдтэй харилцах
- Нийтийн тээвэр
- Ахлах сургууль
- Замын сүлжээ
- Социаль үйлчилгээнүүд
- Байгаль орчин
- Тээвэр
- Бүс нутгийн хөгжил
- Эрүүл мэнд

Дани Улс³⁴

- Анхан шатны боловсрол
- Хүүхдийн халамж
- Ахмад настны халамж
- Цагаач, дүрвэгчдийг нийгэмшүүлэх
- Байгаль хамгаалал болон хог хаягдал
- Ажилгүйчүүдэд дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн эдийн засгийн хөгжил
- Соёл, спорт
- Эрүүл мэндийн халамж
- Эмнэлэг
- Эрүүл мэндийн даатгал
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ
- Социаль үйлчилгээ ба тусгай хэрэгцээт боловсрол
- Бүс нутгийн хөгжил
- Бизнесийг хөхүүлэн дэмжих
- Ажлын байр буй болгох
- Тээвэр
- Хөрсний бохирдлын асуудал

Албани Улс³⁵

Тус улсын анхан шатны нэгж болох коммун нь дараах чиг үүрэгтэй.

³³ А.Цанжид, Төв орон нутгийн харилцаа, чиг үүргийн зохистой хуваарилалт, Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, Конрад-Аденауэр-Сан, УБ, 2017 он, 27 дахь тал.

³⁴ Мөн тэнд, 27 дахь тал.

³⁵ А.Цанжид, Төв орон нутгийн харилцаа, чиг үүргийн зохистой хуваарилалт, Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, Конрад-Аденауэр-Сан, УБ, 2017 он, 28 дахь тал.

- Усан хангамж
- Бохир ус, ус суваг
- Орон нутгийн зам, явган зам, талбай
- Нийтийн тээвэр
- Хог хаягдлыг цэвэрлэх
- Газар болон хотын хөгжил
- Социаль үйлчилгээ
- Соёл
- Орон нутгийн эдийн засгийн хөгжил
- Жижиг бизнесийг хөгжүүлэх
- Мал эмнэлгийн үйлчилгээ
- Нийтийн хэв журам, иргэний аюулгүй байдал
- Оршуулгын газар

Болгар Улс³⁶

- Боловсрол
- Эрүүл мэнд (эмнэлгийн болон нийгмийн халамж, ариун цэвэр, эрүүл ахуй)
- Социаль үйлчилгээ
- Соёл
- Төрийн (public) алба
- Спорт, биеийн тамир
- Усан хангамж, бохир ус
- Аялал жуулчлал
- Айл өрхийн хог хаягдал
- Зам, цэцэрлэг, гадна гэрэлтүүлэг
- Нутаг дэвсгэрийн хөгжил
- Тээвэр
- Төрийн өмчийн байшин барилгыг арчлах
- Байгаль орчин

Үүнээс үзвэл дээрх жишээ болгосон орнуудад орон нутгийн анхан шатны нэгжийн үүрэг нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн анхан шатны үйлчилгээ, хэв журам сахиулах ажиллагаа, гал, усны аюулаас хамгаалах, зам арчилгаа, хог хаягдлыг цуглуулах, газар ашиглалт, төлөвлөлт, байгаль орчныг хамгаалах гэсэн нийтлэг чиг үүргээс бүрдэж байна. Харин орон нутгийн эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, иргэний бүртгэл, хууль сахиулах ажиллагаа гэх мэт салбарын нэгдсэн бодлогоор хангахад чиглэсэн тусгайлсан чиг үүргийг төв засгийн газар хариуцан ажилладаг болохыг харуулж байна.

³⁶ Мөн тэнд, 28 дахь тал.

ДОЛОО.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгаанаас дүгнэн үзэхэд орон нутгийн нэгжийн удирдлага харьяалах нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч тухайн орон нутагт буй агентлагийн дарга нарыг томилох, чөлөөлөх, хариуцлага тооцох эрхийг олгоогүй байна. Энэ нь Засаг даргаас орон нутагтаа захиргааны нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн бодлого үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл үүсгэж байгааг харуулж байна. Иймд судалгааны багийн зүгээс энэ хуулийн 27 дугаар зүйлийн хэрэгжилт сул байна гэж дүгнэж байна. Уг хуулийн 27 дугаар зүйлд тусгагдсан орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа газар, хэлтсийн зарим удирдах ажилтан, албан хаагч нарыг Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд томилох, чөлөөлөх, хариуцлага оногдуулах бүрэн эрхийг олгох үндэслэлтэй гэж үзэж байна.

1.МУЗЗНДНТУтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.5-д засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүргүүдийг жагсааж тусгасан. Эдгээр чиг үүрэг нь Засгийн Газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 37 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт заасан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд байх агентлагуудын чиг үүрэгтэй нийцэж байх бөгөөд Засаг дарга төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхдээ эдгээр агентлагаар дамжуулан, агентлагийн бүтэц зохион байгуулалтыг ашиглан гүйцэтгэхээр байна. Гэхдээ төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэхээр Нэгжийн тухай хуулийн 27-д шууд заагаагүй боловч Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Гаалийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Статистикийн хэлтэс, Татварын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Бүсийн шүүх шинжилгээний төв зэрэг агентлагуудын гүйцэтгэх чиг үүрэг нэгжийн тухай хуулийн 27-д тусгагдаагүй байна.

2.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний дараах агентлагуудын чиг үүргийг салбар салбарын нарийвчилсан хуулиудаар иргэдийн төлөөлөгчдийн хурал болон аймгийн Засаг даргын чиг үүрэг, бүрэн эрхийг хуульд нарийвчлан зохицуулж өгчээ. Үүнд:

Аймгийн Засаг дарга болон аймгийн	Салбарын хуулиуд	Агентлагууд
	Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль	Боловсролын газар
	Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
	Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль	Мал эмнэлгийн газар
	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	Нийгмийн даатгалын газар
	Соёлын тухай хууль	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
	Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	Татварын газар

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд салбар салбарийн нарийвчилсан хуулиар олгож тодорхой чиг үүргийг олгож байна.	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Нийгмийн халалмжийн тухай хууль,	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
	Эрүүл мэндийн тухай хууль Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
	Байгаль орчны тухай хууль, Усны тухай хууль	Гол мөрний ай сав газрын захиргаа
	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль	Улсын тусгай хамгаалалттай газар

3.МУЗЗНДНТУТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн байна. Сайд нарын аймгийн засаг даргатай байгуулж буй гэрээг судлан үзэхэд нийт 19 гэрээ байх бөгөөд үүний 11 нь Хамтран ажиллах гэрээ, 7 нь төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ, 1 нь эрх хэрэгжүүлж үүрэг гүйцэтгүүлэх гэрээ байх бөгөөд сайд нар нийтийн эрх зүйн гэрээгээр дараах чиг үүргүүдийг шилжүүлж байна. Эдгээр гэрээгээр Засаг даргад нийт 652 ажлыг хийж гүйцэтгэх чиг үүргийг шилжүүлсэн, үүрэг хүлээлгэсэн, эдгээр ажлыг гэрээ байгуулсан нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд гэрээг хагас жил тутам дүгнэж, тайланг илгээх үүргийг хүлээлгэсэн байна.

Хамтран ажиллах гэрээ:

- Аж үйлдвэр, эрдэс баялгын сайд
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
- Боловсролын сайд
- Гадаад харилцааны сайд
- Сангийн сайд
- Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд
- Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
- Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
- Эрүүл мэндийн сайд

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ:

- Батлан хамгаалахын сайд
- Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд
- Эрчим хүчний сайд
- Шадар сайд
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар
- Монгол Улсын Шадар сайд

Эрх хэрэгжүүлж үүрэг гүйцэтгүүлэх гэрээ

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

4.Харьцуулсан судалгаанаас үзэхэд судалгаанд авч үзсэн улс орнуудад орон нутгийн чиг үүргийн хуваарилалтыг бүс нутгийн төлөвлөлт, суурь боловсрол, соёлын үйлчилгээ, нийгмийн суурь хангамж, эрүүл мэндийн суурь үйлчилгээ, ус хангамж, цахилгаан хангамж, нийтийн тээвэр, бизнесийг дэмжих гэх мэт хүрээнд авч үзэж байна. Энэ нь Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой хэлбэрээр тусгагдсан боловч дээр судалгаанд дурдагдсан нутгийн өөрийн удирдлагын зарчим, субсидиар зарчим, эрх мэдэл шилжүүлэх (төлөөлүүлэх), бие даасан санхүүжилттэй байх зарчмын хэрэгжилт хангалттай бус байна.

5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болон бусад хууль тогтоомжуудтай уялдаагүй, чиг үүргийн хувьд давхардсан зэрэг асуудлыг тодруулах шаардлагатай байна. Түүнчлэн орон нутгийн чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид оновчтой хуваарилах, ялангуяа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэх, мөн орон нутгийн чиг үүргийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэхэд зарчмыг баримтлах шаардлагатай.

Ингээд судалгааны багийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна.

1.Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Татварын газар, Улсын тусгай хамгаалалттай газрын удирдлагыг “Засаг даргын санал болгосноор эсхүл Засаг даргатай зөвшилцсөний дагуу төрийн захиргааны төв байгууллага томилох”;

2.Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Гол мөрний ай сав газрын захиргааны удирдлагыг “Төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор эсхүл зөвшилцсөнөөр тухайн шатны Засаг дарга томилох, чөлөөлөх”;

3.Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлагыг “Засаг дарга өөрийн бүрэн эрхийн хүрээнд дангаар томилох” агуулгаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхэд Засаг даргын харьяа агентлагийн дарга, удирдлагыг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг тусгаагүй, ийм агуулга бүхий заалт байхгүй байгаа нь Засаг даргын харьяа агентлагын даргыг томилох эрх хэмжээг хязгаарласан нөхцөл байдлыг үүсгэж байгаа тул уг хуулийн хобогдох хэсэгт “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлөх” гэсэн агуулгаар нэмэлт, өөрчлөлт шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж

1. “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”, 2020 он
2. Ж.Амарсанаа нар, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл” сүүлийн 20 жилийн тойм, Нээлттэй нийгэм форум, УБ 2010 он.
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хувийн хэрэг, боть 1, УИХ-ын Тамгын газар. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ, 2019 он.
4. Я.Бямбаяр, Нутгийн өөрийн удирдлагын асуудлууд: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүргийн хэрэгжилтийн судалгаа, Удирдлагын академи, УБ, 2023 он.
5. Л.Отгонтуяа нар, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтад хийсэн шинжилгээ, Удирдлагын академи, УБ, 2021 он.
6. А.Цанжид, Төв орон нутгийн харилцаа, чиг үүргийн зохистой хуваарилалт, Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, Конрад-Аденауэр-Сан, УБ, 2017 он
7. Өмгөөллийн Ивээл баг” ХХН, судалгааг Д.Сүнжид, А.Бямбажаргал, Н.Баярмаа, Г.Сурахбаяр, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа нарын бүрэлдэхүүнтэй, ННФ-ын санхүүжилтээр “Газрын хэвлийн баялаг ашиглахтай холбоотой Засгийн газар ба Орон нутгийн чиг үүргийн хуваарилалт” УБ хот, 2024 он.
8. Хүний хөгжил сургалтын төв, “Шинэчлэн баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл, төсвийн шилжүүлэгт үзүүлэх үр нөлөө”, УБ, 2021 он.
9. Л.Золзаяа, Л.Лувсанжамц нар, Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал, Нээлттэй нийгэм форум, УБ, 2003 он.
10. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний 37-р тогтоол.

Хавсралт 1.Хүний эрхэд үзүүлэх нөлөө

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн чиг үүрэг, түүнд тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчилна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Бүх шатны засаг дарга ба Ерөнхий сайдын эрх хэмжээ, чиг үүрэгт тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Үндсэн хуульд тусгагдсан иргэд болон төрийн эрх бүхий байгууллагын чиг үүрэг, уялдаа холбоог хангах зарчимд тулгаарлан сөрөг үр дагаварыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн байгууллагууд болон судалгаанд хамрагдсан эрх, ашиг сонирхол хөндөгдсөн этгээдүүдийн ирүүлсэн саналыг үндэслэж хуулийн төслийг боловсруулна.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон хүний эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.

	эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн зэрэг холбогдох этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд заасны дагуу тооцно.
Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага ба бүх шатны засаг даргын чиг үүрэгт тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүх шатны засаг дарга Орон нутгийн хурал Үйлчүүлэгч иргэд
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ерөнхий сайд, төрийн захиргааны төв ба орон нутгийн байгууллагуудын хүлээх үүрэг, чиг үүргийг ялгамжтай тогтооно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Төрийн төв болон орон нутгийн байгууллагуудын бүрэн эрх, чиг үүрэгт тавигдах шалгуур, үйл ажиллагаа явуулах, хяналтын бүх нөхцөлд жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хүснэгтийн 5.1-д заасан тайлбартай адил.

Хавсралт 2.Эдийн засагт үзүүлэх нөлөө

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Уг хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд төрийн төв ба орон нутгийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд тайлан мэдээллээ гаргана.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тухайн орон нутагт төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хуулийн этгээдүүд байгууллагдаж ажиллана.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Урт хугацаандаа улсын төсөвт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн дагуу зарим чиг үүрэг нэмэгдэх боловч дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

Хавсралт 3.Нийгэмд үзүүлэх нөлөө

(Хүснэгт 5)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн чиг үүрэг, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2	Аж үйлдвэр, эрдэс баялгын сайд	Хамтран ажиллах гэрээ -Салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх -17 -Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоожийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг -14 -Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах, таниулах, мэдээ мэдээллээр хангах -12 Нийт 43 ажил байна. Төрийн чиг үүргийг шилжүүлээгүй байна.
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Хамтран ажиллах гэрээ -Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд -Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд -Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд -Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах хүрээнд -Усны нөөцийн ашиглалт, хамгаалах хүрээнд -Ойн нөөцийг ашиглалт, хамгаалт зорилтын хүрээнд -Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажил. Нийт 68 ажил байна.
4	Батлан хамгаалахын сайд	Батлан хамгаалах зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ -Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд -Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгох, сумдын дайчилгааны даалгавар, дайчилгааны төлөвлөгөөг шинээр

		боловсруулан батлуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах -Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангах зорилгоор цугларалт, хээрийн дадлага явуулах -Цэргийн тоо бүртгэл, цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах, цэргийн дүйцүүлэн албаны сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийлгэх хүрээнд -Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах хүрээнд нийт 25 ажил байна.
5	Боловсролын сайд	Хамтран ажиллах гэрээ -Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд -36 -Боловсролын салбарт менежмент, хүний нөөц эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр -25 -Боловсролын салбарын санхүү, төсвийн удирдлага, хэрэгжилтийн чиглэлээр- 6 Нийт 67 ажил хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна.
6	Гадаад харилцааны сайд	Хамтран ажиллах гэрээ Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд 10 зүйл тусгасан.
7	Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ -Хот байгуулалтын чиглэлээр 8 -Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр 5 -Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр 6 -Орон сууцны чиглэлээр 3 Нийт 22 ажил хэрэгжүүлэхээр байна.
8	Эрчим хүчний сайд	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ -Нийт 28 чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар тусгасан
9	Шадар сайд	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ -Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хариуцан ажиллаж буй аймгийн улсын байцаагчийг давтан сургах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг нийт 15 үүргийг хүлээлгэсэн байна. -Нийт 26 чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар тусгасан
10	Сангийн сайд	Хамтран ажиллах гэрээ -Санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд тухайн орон нутагт аргай зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангаж, зохицуулах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, түүний үр дүнг Сангийн сайдын өмнө хариуцах зэрэг нийт 50 үүргийг хүлээлгэсэн.
11	Соёл, спорт, аялал	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ

	жуулчлал, залуучуудын сайд	-Соёл урлагын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр-12 -Соёлын өвийг хадгалах, хамгаалах чиглэлээр- 7 -Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр-9 -Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр-6 -Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр-6 Нийт 40 ажил.
12	Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	Хамтран ажиллах гэрээ -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлын хүрээнд- 6 -Цахим мэдээллийн системийг хөгжүүлэх хүрээнд - 2 -Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлын хүрээнд-3 -Оюуны өмчийн чиглэлээр- 2 Нийт 13 ажил.
13	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Хамтран ажиллах гэрээ -Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, Захиргааны хэм хэмжээний тогтоосон шийдвэрийн бүртгэлийн чиглэлээр-3 -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр-9 -Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр- 1 -Шүүх шинжилгээний чиглэлээр- 1 -Архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр- 1 -Хууль зүйн туслалцааны чиглэлээр- 1 Нийт 16 ажил.
14	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ -Төсвийн тухай болон Монгол Улсын 2025 оны төсвийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд -"Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", 3Г-ийн үйл ажиллагааны хөтөлбөр, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх хүрээнд -Орон нутгийн өмчид аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд -Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд -Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд -Газрын харилцаа, геодези, зураг зүй, орон зайн дэд бүтцийн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд -Монгол хэлний тухай стнадартыг харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд мөрдүүлэх, үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах -Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтуудад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжин ажиллах -Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвөгөөний хэрэгжилтийг

		хангах, аймгийн жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрт явцын болон эцсийн хяналт, шинжилгээ-үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, дараагийн шатны холбогдох бодлого, төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх Нийт 33 ажил байна.
15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Хамтран ажиллах гэрээ -мал аж ахуйн үйлдвэрлэл-10 -Газар тариалангийн үйлдвэрлэл- 4 -Хүнс үйлдвэрлэл- 9 -Хөнгөн үйлдвэрлэл- 4 -Жижиг дунд үйлдвэрлэл- 5 Нийт 32 ажил байна.
16	Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга	Хамтран ажиллах гэрээ -Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөнд аймаг орон нутагт хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудыг хэрэгжүүлэх, зохион байгуулах. Нийт 4 ажил байна.
17	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	Хамтран ажиллах гэрээ -Харилцаа холбооны дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр -Цахим засаглалыг бэхжүүлэх, Дижитал аймаг, дижитал хот зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр -Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр Нийт 21 ажил байна.
18	Монгол Улсын Шадар сайд	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ -Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, бүсүүдийн хөгжлийн чуулган арга хэмжээ зохион байгуулах зэрэг нийт 26 үүрэг хүлээлгэсэн
19	Эрүүл мэндийн сайд	Хамтран ажиллах гэрээ -Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 12 -Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр 12 -Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр 4 -Хүний нөөцийн чиглэлээр 4 -Бусад үйл ажиллагааны чиглэлээр 8 Нийт 40 ажил байна.
Засаг даргад гэрээний үндсэнд нийт 652 чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар тусгасан байна.		

Хавсралт 8. Засаг даргад томилгооны бүрэн эрх олгох шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Боловсролын газар	Эрүүл мэндийн даатгалын хөлтөс	Улсын тусгай хамгаалалттай газар	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Мал эмнэлгийн газар	Нийгмийн даатгалын газар	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	Татварын газар	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Гол мөрийн аймаг газрын захиргаа
Нэгжийн тухай хуулиар төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэгт хамаарч байгаа эсэх	27.5.2, 27.5.3	27.5.4	27.5.10	27.5.5, 27.5.6	27.5	27.5.5, 27.5.7	27.5.8, 27.5.19		27.5.5, 27.5.6, 27.5.7	27.5.10
Салбарын нарийвчлсан хуулиар Засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн цар хүрээтэй чиг үүргийг олгосон	Боловсролын газар, хууль, Сургуулийн өмнөх болон өрөнхий боловсролын газар тухай хуулиар өргөн цар хүрээтэй чиг үүргийг олгосон	Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн дагуу өргөн үүргийг	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулиар өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиар өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Мал амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай хуулиар өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Нийгмийн даатгалын өрөнхий хуулийн 45 дугаар зүйлд тусгаснаар Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үүргийг	Соёлын тухай хуулиар өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Татварын өрөнхий хууль, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу Засаг дарга өргөн чиг үүрэг	Нийгмийн халамжийн тухай хуулиар өргөн чиг үүрэг хэрэгжүүлж байна.	Усны тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай зэрэг хуулиар өргөн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

олгосон эсэх.	хэрэгжүүлж байна.	хэрэгжүүлж байна.	хүлээж байна.	хүлээж байна.	хэрэгжүүлж байна.	хэрэгжүүлж байна.	хэрэгжүүлж байна.	хэрэгжүүлж байна.
Чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүжилтийг орон нутаг хариуцахаар хуульд заасан эсэх.	Орон нутгийн төсөвт төсөвт байгууллага буюу сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардал багтдаг. Мөн Нэгжийн хуулийн 27.2-т зааснаар зардлыг шилжүүлж байна.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу Төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр шийдвэрлэж байна.	6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх 2. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 1/ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;	52.4.Төр хүүхэд хамгааллын асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлж, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасны дагуу улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжигдэж байна.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу Төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр шийдвэрлэж байна.

харгалзан үзэх.	хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын н байгууллага, боловсролы н асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролы н сургалтын байгууллага н удирдлагаас бүрдэнэ.	эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, а, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ.	хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээний хээ хүрээнд хяналт тавина.	га, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн	бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина.	а, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ.	захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.	77.1.Татварын албан нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.	дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ.	хариуцсан төрийн захиргааны байгууллага ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.
-----------------	---	--	---	---	--	--	--	--	--	--

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ГАРЧИГ	
Удиртгал	3
Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал	4
Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	5
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:	5
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:	5
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:	5
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:	5
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:	5
Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал	6
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	6
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	8
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	8
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	9
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	9
Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал	11
4.1. Үнэлэлт, дүгнэлт	11

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж тусгасан. Энэ хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баталсан.

Энэхүү үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /МУЗЗНДНТУТХ/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-д Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлгээ хийж, хуулийн төслийг боловсронгуй болгох санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

- 1.шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг хамаарна.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуураас 5 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ. Үүнд:

- 1.зорилгод хүрэх байдал
- 2.практикт хэрэгжих байдал
- 3.ойлгомжтой байдал
- 4.хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 5.харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн.
Үүнд:

1.Хуулийн төсөл нь зорилгодоо хүрэх эсэхийг дараах хэдэн үзүүлэлтийг харгалзан үзэв. Үүнд:

- МУЗЗНДНТУтХ-д заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах суурь нөхцөл хангагдах эсэх;
- Төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах суурь нөхцөл бүрдэх эсэх;
- Орон нутагт төрийн захиргааны мэргэшсэн ажилтан карьер хөөх, засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилохдоо орон нутагтаа мерит зарчим хангуулах боломж бүрдэх эсэх зэрэг.

2.Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд хуулийн төсөл ойлгомжтой, логик уялдаатай боловсруулагдсан эсэх;

3.Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, зорилгодоо хүрэх, хүлээн зөвшөөрөгдөх байдал зэргийг тус тусад нь шалгана.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох хэсгийг сонгов. Эдгээр хэсгийг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа ач холбогдол бүхий байдлаар нь сонгож авсан. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, эсхүл голлох ач холбогдол бүхий хэсгийг сонгож, тухайн сонгосон хэсгийн үр нөлөөг судаллаа.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзлээ.

2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь үнэлэв. /Хуулийн төсөл 5 зүйл, 5 хэсэгтэй./

2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь үнэлэв. /Хуулийн төсөл 5 зүйл, 5 хэсэгтэй./

2.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 5 зүйл, 5 хэсэгтэй./

2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 5 зүйл, 5 хэсэгтэй./

2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 5 зүйл, 5 хэсэгтэй./

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн зорилгод дүн шинжилгээ хийсэн.
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхийг аж ахуйн нэгжийн төлөөллөөс асуумж авах аргаар үнэлсэн.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгасан.
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа болон аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх гэсэн асуулгаар шалгасан.
5.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгасан.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцааны хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хуулийн төслийн үндсэн зорилго нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхийг үнэлэв.

- МУЗЗНДНТУтХ-д заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах суурь нөхцөл хангагдах,
- Төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах суурь нөхцөл бүрдэх,
- Орон нутагт төрийн захиргааны мэргэшсэн ажилтан карьер хөөх, засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилохдоо орон

нутагтаа мерит зарчим хангуулах боломж бүрдэх эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэгдсэн байна.

Нэг.Засаг дарга бол төр, засгийн төлөөлөгч юм. Энэ утгаараа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцахаар хуульд заасан. Гэвч өөрөө бие дааж хариуцах хэмжээнд эрх бүрэн олгогдоогүй байна. Тиймээс засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагаа өөрөө томилж, чөлөөлж, гэрээ байгуулж, урамшуулж, хариуцлага тооцох боломжтой болгохоор энэхүү хуулийн төслөөр зохицуулж өгч байгаа болно.

Нөгөө талаас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас сонгогдсон орон нутгийн удирдлага бөгөөд МУЗЗНДНТУтХ-ийн 60 дугаар зүйлийн 60.1.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах гэж зааж өгсөн. Энэ утгаараа засаг дарга орон нутгийн чиг үүргийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг мөн хуулиар бүрэн олгохын тулд энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт үр дүн өгөх юм.

Хоёр.Хуулийн төсөлд “Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.” гэж өөрчлөн найруулснаар сумаас гадна аймагт чадвартай, туршлагатай хүний нөөцийг тогтоох, тогтвортой ажиллуулах боломж бүрдэх юм.

Дээрх гол хоёр чиглэлд хуулийн төсөл нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн хэрэгжилтэд дараах эерэг өөрчлөлт гарна:

- Төрийн байгууламжийн нэгдмэл байдал хөндөгдөхгүй. Учир нь энэхүү хуулийн төслөөр МУЗЗНДНТУтХ-иар тогтоосон орон нутгийн чиг үүргийг хөндөхгүй бөгөөд нэгэнт ялгаж, зааглан давхардлыг нь арилгаж өгсөн энэ чиг үүргийг хөндөхгүй. Мөн МУЗЗНДНТУтХ-ийн 76 дугаар зүйлийн 76.3-д орон нутгийн чиг үүргийг өөрчлөх хуулийг зөвхөн Засгийн газар санаачлахаар хуульчилж өгсөн нь төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хамгаалсан зохицуулалт гэж үзэж байна.
- Улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах зарчим хангагдана. Засаг дарга бол хосолмол удирдлагын чиг үүрэгтэй бөгөөд нэг талаас нутгийн өөрөө удирдах ёсны, нөгөө талаас төр засгийн төлөөлөгчийн үүргийг хэрэгжүүлдэг. Энэ утгаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хуульд тусгайлан зааж өгсөн байх тул тухайн чиг үүргээ хэрэгжүүлэхэд засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг засаг дарга томилдог болгож өгснөөр улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах зарчим хангагдана.
- МУЗЗНДНТУтХ-ийн хуулийн засаг даргын бүрэн эрхэд заасан “хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах” боломж бүрдэнэ.
- МУЗЗНДНТУтХ-ийн хуулийн засаг даргын бүрэн эрхэд заасан “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” боломж бүрдэнэ.

Иймд хуулийн төслийн тусгагдсан зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцсэн, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг зохицуулалтыг дагаж мөрдөх боломжтой эсэх, дагаж мөрдсөнөөр үр дүн хэрхэн гарахыг тодорхойлох зорилгоор аймаг, дүүргийн ИТХ-ын дарга, засаг дарга нараас түүврээр асуулгын судалгаа авсан болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд холбогдох дараах тулгамдсан асуудал тулгарч байна. Өнөөгийн байдлаар орон нутаг (аймагт)-т 46 нэгж албан байгууллага болон хуулийн этгээд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж иржээ. Үүнээс 12 нэгж хуулийн этгээдийн удирдлагыг Засаг дарга, 34 байгууллагын удирдлагыг төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхийн төрийн захиргааны төв байгууллагаас томилж байна. Үүнээс үүдэн Засаг даргаас орон нутагтаа захиргааны нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн бодлого үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл үүссэн, мөн шат шатны Засаг дарга тухайн орон нутагт буй орон нутгийн газар, хэлтсийн ажилтан, албан хаагч нарт хариуцлага тооцох эрх хязгаарлагдмал сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Энэ нь иргэдэд төрийн үйлчилгээг нэгдсэн бөгөөд тэгш, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэжээ.

МУЗЗНДНТУтХ-ийн шинэчилсэн найруулга 2020 онд батлагдсанаар орон нутгийн чиг үүргийг төрийн чиг үүргээс зааглан ялгаж, улмаар нэгж хоорондын давхардлыг арилгасан бөгөөд мөн төрийн чиг үүргийн орон нутагт төлөөлүүлэн гүйцэтгүүлэх асуудлыг уг хуулиар зохицуулж өгсөн нь цаашид орон нутаг бие даан хөгжих боломж эрх зүйн орчны хувьд бүрдсэн болно.

МУЗЗНДНТУтХ-ийн 27 дугаар зүйлээр төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг тогтоож өгч, улмаар Засгийн газрын тогтоолоор засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг тогтоож өгдөг хэдий ч өнөөдрийг хүртэл төрийн чиг үүргийг шилжүүлэх төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд нь орон нутаг дахь салбар, агентлагуудын удирдлагуудын томилгоог шилжүүлэхгүй явж ирсээр байна. Энэ нь нэг талаас МУЗЗНДНТУтХ-д томилгооны асуудлыг тодорхой зааж өгөөгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Иймд МУЗЗНДНТУтХ-д засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагын томилгоог засаг даргын бүрэн эрхэд тусгаж өгснөөр практикт хэрэгжих боломж бүрдэнэ.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

МУЗЗНДНТУтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан.

Нэг талаас хуульд засаг даргын чиг үүрэг, нөгөө талаас төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг ч мөн адил хуульд тодорхой зааж өгөөд, улмаар Засгийн газрын тогтоолоор засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг

жагсааж тогтоож өгсөн атлаа түүний удирдлага, арга зүйгээр хангах, менежментийг сайжруулах чиглэлд удирдлагыг томилж, чөлөөлж, хариуцлага тооцох боломж олгохгүй байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгоод байсан. Энэ нь ч нөгөө талаар орон нутаг бие даан хөгжихгүй байгаагийн шалтгаан гэж харж байна.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

МУЗЗНДНТУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж, МУЗЗНДНТУТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.” гэж заасан заалтууд практикт хэрэгжих суурь тавигдаж, хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Ингэснээр төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг орон нутагт засаг дарга хариуцан хэрэгжүүлэхэд засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг Засаг дарга томилох байдал төрийн захиргааны төв байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөх юм. Гэтэл одоогийн байдлаар МУЗЗНДНТУТХ-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэх атлаа удирдлага, зохион байгуулалтаар хангаж чадахгүй, нөгөө талаар засаг даргад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрх хуульд тусгайлан олгогдоогүй байгаа, мөн тухайн салбарын хуульд салбар, агентлагийн удирдлагыг төрийн захиргааны байгууллага дээрээсээ томилохоор заасан байгаа учраас хүлээн зөвшөөрөгдөхгүй байсан.

Иймд МУЗЗНДНТУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилж, чөлөөлөх тухай зохицуулалт оруулж өгснөөр төрийн захиргааны төв байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөх болно.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

1.	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
2.	Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4.	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардал, хийдэл үүссэн эсэх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагуудын удирдлагыг томилж, чөлөөлөх эрхийг тусгаж өгснөөр салбарын дараах 17 хуулийн холбогдох заалтыг өөрчлөн найруулахаар мөн хуулийн төслүүдийг дагалдуулан өргөн мэдүүлж байна. Үүнд: 1.Боловсролын Ерөнхий хууль 2.Хүүхэд хамгааллын тухай хууль 3.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль 4.Эрүүл мэндийн даатгалын тухай 1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль 3. Нийгмийн халамжийн тухай хууль 4. Соёлын тухай хууль 5. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль 6. Статистикийн тухай хууль 7. Татварын Ерөнхий хууль 8. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 9. Усны тухай хууль 10. Гамшгаас хамгаалах тухай 11. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 12. Цагдаагийн тухай хууль 13. Улсын бүртгэлийн ерөнхий хууль
5.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
6.	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Давхардлыг арилгах талаар хуулийн төсөлд болон дагалдах хуулийн төслүүдэд тодорхой зохицуулсан.
8.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Энэ хуулийн төслөөр татвар, төлбөр, хураамжийг тогтоох асуудал хөндөгдөхгүй
9.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Энэ хуулийн төсөлд шинээр тусгай зөвшөөрөл бий болгох зохицуулалт тусгагдаагүй.

10.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн.
11.	Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл заалт байхгүй.
12.	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн, бий болгосон заалт байхгүй.
13.	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан зүйл, заалт тогтоогдоогүй болно.
14.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслөөр хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт байхгүй болно.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1.Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийсний үр дүнд дүгнэвэл, Засаг дарга нь МУЗЗНДНТУТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасан “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэсэн хуулийн тодорхойлолт бүрэн хангагдаж дараах зорилгод хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” гэсэн заалтын хэрэгжилт хангагдана.

2.МУЗЗНДНТУТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д заасан “нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх” заалтын хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.

3.МУЗЗНДНТУТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх эрхийн баталгааг хангах нөхцөл бүрдэнэ.

4.МУЗЗНДНТУТХ-д заасан “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” заалт хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

5.МУЗЗНДНТУТХ-д заасан “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” заалт хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

6.МУЗЗНДНТУТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ” гэсэн заалт хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь бүхэлдээ практикт хэрэгжих боломжтой буюу МУЗЗНДНТУТХ-д засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж, чөлөөлөх эрхийг засаг даргад олгосноор салбарын хуулиудийн холбогдох заалтыг өөрчлөн найруулж, түүнд тулгуурлан засаг дарга нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилж чөлөөлөх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, улмаар чадвартай, туршлагатай мэргэшсэн хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, мерит зарчим хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

МУЗЗНДНТУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж, МУЗЗНДНТУТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.” гэж заасан атлаа засаг дарга нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагуудыг томилж чөлөөлөх эрх олгогдохгүй байсан учраас иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон Засгийн газар (дээд шатны засаг дарга)-ын шийдвэрийг хэрэгжүүлэх боломж олгогдохгүй байсан. Ийм учраас засаг дарга нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах боломжгүй болж, уг хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх байдал нь ойлгомжгүй байсаар ирсэн.

Хуулийн холбогдох заалтуудаар засаг даргад олгогдсон үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгож, ойлгомжтой байдал үүсгэхэд энэхүү хуулийн төсөл үүргээ гүйцэтгэнэ.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслөөр засаг даргад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилох зохицуулалтыг оруулж өгснөөр салбарын

холбогдох хуулиудад мөн адил холбогдох заалтуудыг өөрчлөн найруулснаар төрийн захиргааны төв, төрийн захиргааны холбогдох байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөнө.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлуудыг тодруулж, хуулийн төслийн дотоод болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай байх 14 төрлийн асуулгаас МУЗЗНДНТУт хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бүхэлд нь хангасан, уялдаа холбоотой болсон байна гэж дүгнэв.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль²-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;³
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;⁴
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁵
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁶

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог. Харин тус хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй тул аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/16106891904801>

³ Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

⁴ Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

⁵ Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

⁶ Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

Хоёр.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолно. Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолдог. Үүнд:

- 2.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгосон зохицуулалт байхгүй байна.

Гурав.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг аргачлалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах дарааллыг баримтлан тогтооно. Үүнд:

- 3.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэнд шинээр гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгох зохицуулалт байхгүй байна.

Дөрөв.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо

Аргачлалын 4.1-д зааснаар Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;


- 4.3.гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн зохицуулалт тусгаагүй тул улсын төсөвт шинээр зардал үүсэхээргүй байна.

---oOo---

ИРГЭД, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ БАГЦЛАН
 МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
 НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БАЙДАЛ

№	Иргэн, хуулийн этгээдийн нэр	Саналын томъёолол	Хуулийн төсөлд тусгасан байдал, тайлбар
1	Иргэдээс цахимаар авсан санал асуулга	2. Аймгийн ихэнх агентлагийн дарга, удирдлагыг орон нутгийн оролцоогүйгээр яамнаас босоо томилдог, төрийн ажлын уялдаагүй байдл...н нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь зөв үү. 634 responses 79% 18.9% - Зөв, дэмжиж байна. - Буруу - улс төр хэтэрхий их орох байх - Мөдөхгүй - Зөв хүн сонгогдовол зөв. Буруу хүн б... - Сайн мэдэхгүй байна 2 талтай гэж харж байна. .чаг - Мэдэхгүй ээ 1/2 ▼	

4	6. Хайгуулын болон ашиглалтын лицензийг олгохдоо сум, аймгийн саналыг үндэслэн олгодог байх талаар хуулийн өөрчлөлт хийвэл та дэмжиж байна уу? 633 responses  Тийм, дэмжиж байна Дэмжихгүй байна Мэдэхгүй. Ард иргэдийн санал бодлыг сонсох... Иргэд нийтийн санал авах. Сумын нутаг дэвсгэрт харьяалалтай... Ард иргэдийн саналыг үндэслэх Цаазл суманд хайгуул хийж яваа хүм... 1/2 ▼	
5	1. Аймгийн ихэнх агентлагийн дарга, удирдлагыг орон нутгийн оролцоогүйгээр яамнаас босоо томилдог, төрийн ажлын уялдаагүй байдлыг өөрчилж, аймаг, нийслэлийн засаг дарга нь томилон, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь зөв үү. (550 иргэдээс санал авч 401 буюу 72.9 хувь нь Зөв, дэмжиж байна.)	
6	2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болдог. Цаашид мөн адил аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болох нэмэлт өөрчлөлтийг та дэмжих үү? (550 иргэдээс санал авч 357 буюу 64.9 хувь нь Тийм, дэмжиж байна.)	Иргэдээс цаасаар авсан санал асуулга
	3. Багийн Засаг даргыг хэрхэн сонгодог байх нь зөв бэ? (550 иргэдээс санал авч 376 буюу 68.4 хувь нь Багийн Иргэдийн Нийтийн хурлаас сонгодог одоогийн арга зөв.)	

	4. Хайгуулын болон ашиглалтын лицензийг олгохдоо сум, аймгийн саналыг үндэслэн олгодог байх талаар хуулийн өөрчлөлт хийвэл та дэмжиж байна уу? (550 иргэдээс санал авч 371 буюу 67.5 хувь нь Тийм, дэмжиж байна.)	
--	--	--

---ooOoo---